Сурагчдын сурах хүсэл эрмэлзлэлийг дээшлүүлэн, бие даасан бүтээлч үйл ажиллагааг хөгжүүлсэн. Төсөлт ажил нь хүүхдүүдийн идэвхийг өрнүүлээд зогсохгүй, бусад хичээлд нь ч эерэг нөлөө үзүүлсэн хэмээн багш нар ярьж байна.

Гурван зөвлөмжийг цогц байдлаар агуулгын хувьд уялдаа холбоотой бичсэн тул өнгөц унших бус нэгд нэггүй уншиж судлах нь зүйтэй.

### М.Ганбат, МУИС-ийн Физик электроникийн сургуулийн Физик боловсролын тэнхимийн эрхлэгч (Физикийн зөвлөмж боловсруулах багийн ахлагч)

Өмнөх төслийн эхний үед юу хийх ёстой нь ойлгомжгүй байсан ч явцын дунд зөвлөмж боловсруулах ажилд тодорхой сэдэв дээр тодорхой үүрэгтэйгээр оролцох болсон. Үүний дүнд 7, 8, 9-р ангид заадаг “Цахилгаан гүйдэл” бүлэг сэдвээр зөвлөмж боловсруулсан ба зөвлөмжид физикийн арга зүйн онцлог, нэгж болон ээлжит хичээлийн судалгаа хийх үе шат, алхмуудаас гадна хичээлийн киррикулим боловсруулснаараа онцлогтой. Энэ нь багш нарын хичээлийн хөтөлбөр боловсруулахад тус нэмэр болсон болов уу. Зөвлөмжийг туршиж үзсэн багш нар сурсан зүйлээ хичээлдээ байнга ашиглан, өөрсдийгөө хөгжүүлэхээр хичээн ажиллаж байна. Түүнчлэн бусад багш нар ч мөн ийм хандлагатай болсон.

Энэхүү төслөөр хэрэгжүүлдэг хичээлийн судалгаа нь, багшийн арга зүйд үнэлгээ өгч, ерөнхийд нь сайн муу хичээл боллоо гэж үнэлээд өнгөрдөг арга зүйгээс зарчмын хувьд ялгаатай юм. Багш нар хамтран хичээлийг олон талаас нь судлах бөгөөд тэрхүү судалгаандаа үндэслэн хичээлд бэлтгэж,

харилцан суралцах явдалд гол анхаарлаа хандуулах нь чухал.

Манай орны боловсролын байгууллагуудын шат шатны төлөөлөл төслийн хоёр дахь шатанд идэвхитэй оролцож байгаа нь туйлын чухал. Төслийн эхний шатанд өөр мэргэжлийн хүмүүс хамтарч нэг асуудлыг шийдвэрлэж байсан нь урьд байгаагүй ололт байлаа. Харин багаар ажиллах тал дээр бид улам ихийг сурах шаардлагатай байна. Учир нь төслийн эхний шатаар дамжуулан багш, мэргэжилтнүүд гайхалтай өссөн нь хамтын ажиллагааны үр дүн гэж хэлж болно.

### Ц.Намжилдорж, Нийслэлийн 45-р сургуулийн захирал (Нэгдүгээр шатны төсөлд загвар сургуулиар оролцон хичээлийн судалгаа, хичээлийн бэлтгэл судалгаа хийх арга зүйд суралцаж, түршилт хичээлүүд зохион байгуулсан)

Төслийн эхний шат сургуулийн түвшинд амжилттай хэрэгжсэн нь боловсролын бүх шатны байгууллагын хамтын ажиллагааны үр дүн юм. Их дээд сургуулийн багш нарын онолын мэдлэг, дунд сургуулийн багш нарын хүүхэдтэй ажиллах туршлагаа харилцан солилцож бие биенээсээ суралцсан. Зөвлөмж нь төсөлд оролцсон бүх хүмүүсийн оюуны бүтээл болж чадсан.

Өмнөх төслийн эхний үед мэдлэг дамжуулах хуучин арга зүйгээс сурагчдаар мэдлэг бүтээлгэх шинэ арга зүйд суралцах явцад зөрчил үүсч, хичээлийн бэлтгэлд маш их цаг зарцуулж байлаа. Хичээлийн хэлэлцүүлгийн үед багшийг шүүмжлэх сэтгэлгээ давамгайлж байсан ч, яваандаа өөрчлөгдөн бие биенээ дэмжиж тусалдаг болсон. Багш нар сурагчдыг сэдэлжүүлэх, мэдлэг бүтээлгэх, идэвхийг өрнүүлэх, чадвар эзэмшүүлэх тал дээр түлхүү анхаарах болсон. Хичээлийн агуулгыг амьдралтай холбон, уламжлалт аргыг шинэ аргатай хослуулан заадаг болсон.

Цаашид арга зүйн шинэчлэлийг улам бүр түгээн дэлгэрүүлэхийн тулд зөвлөмжүүдийг сайтар уншиж судлах шаардлагатай юм. Удирдлага, багш нар сургалтын шинэ арга зүй болон хичээлийн судалгааны талаархи нэгдсэн зөвлөмж гаргаж, багш нар тэрхүү зөвлөмжийн дагуу хичээлээ зааж, хичээлийн судалгаа хийх хэрэгтэй. Мөн, сургууль бүрийн онцлогт тохируулан менежмент боловсруулах хэрэгтэй.

(Үргэлжлэлийг хуудас 3-аас үзнэ үү)

## Төсөлд оролцогчидтой хийсэн ярилцлага (үргэлжлэл)

### Ё.Алтангэрэл, Дорнод аймгийн “Хан-Уул” ногцолбор сургуулийн сургалтын менежер (Нэгдүгээр шатны төслийн загвар сургуулийн төлөөлөл)

Нэгдүгээр шатны төслийн давуу тал нь онолын өндөр мэдлэгтэй их дээд сургуулийн багш нар болон хүүхэдтэй ажиллах баялаг туршлагатай дунд сургуулийн багш нарын харилцан уялдаатай хамтын ажиллагаа байсан. Хичээлийн судалгааг хэрхэн хийх, хичээлийн хэрэглэгдэхүүн болон сургалтын материалыг хэрхэн бэлтгэх, багаар ажиллахын чухлыг ойлгосон.

Эхний үед сурагчдаар мэдлэг бүтээлгэх явцад их цаг зарцуулж байсан ч аажимдаа энэ бэрхшээл үгүй болсон. Багш нар хичээлийн хэрэглэгдэхүүнийг зөв оновчтой тооцох, амьдралд суурилсан мэдлэг бүтээлгэхэд голлон анхаарах болсон. Мөн, гарын доорхи материал ашиглан хэрэглэгдэхүүнээ бэлтгэх болсон. Сурагчид хичээлд идэвхитэй оролцох болсон зэргээр хичээлд хандах хандлага ч өөрчлөгдсөн.

Төслийн хоёр дахь шатанд өнөөг хүртэл төсөлд хамрагдаагүй багш, мэргэжилтнүүдэд зориулсан сургалт явуулж, зөвлөмжийг бүх багш нарт гарын авлага болгон ашиглуулж сурах шаардлагатай байна. Мөн, багш нар судлагдахуун тус бүрээр баг бүрдүүлэн, хамтарч хичээлийн судалгаагаа хийх нь чухал юм.

### Д.Сүвдаа, Сэлэнгэ аймгийн БСГ-ын ахлах мэргэжилтэн (Сэлэнгэ аймгийн загвар гурван сургуульд түршилт хичээл явуулахад дэмжлэг үзүүлдэг)

Төслийн нэгдүгээр шатанд Сэлэнгэ аймгийн загвар гурван сургууль дээр туршилт хичээл хийх бэлтгэл ажлыг хангаж, хичээлийн ажиглалт, хэлэлцүүлэг зохион байгуулах замаар хичээлийн хөтөлбөрийг сайжруулах арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Арга зүйн шинэчлэлд ихээхэн цаг хугацаа шаардагдах бөгөөд хичээлийн зарим хэрэглэгдэхүүн дутагдах бэрхшээл гарч байсан.

Харин төсөл хэрэгжих хугацаанд асуудлыг томъёолох, шийдвэрлэх, таамаглал дэвшүүлэх, турших, ажиглах, хэлэлцүүлэг хийх зэрэгт суралцсан.

Мэдээлэл дамжуулах сургалтаас мэдлэг бүтээлгэх сургалтын арга зүйд шилжин, сурагчид хамтарч асуудлаа шийдэх болсноор сурагчдын сурах идэвхи, хүсэл эрмэлзлэлийг дээшлүүлж чадсан. Загвар бус сургуулиудын 280 багшид арга зүйн шинэчлэлийн сургалт явуулсан нь үр дүнтэй болсон.

Багш нарын ажилдаа хандах хандлага сэтгэлгээг өөрчлөх нь арга зүйн шинэчлэл дэх тулгамдсан асуудал юм. Багш нар хичээлийн бэлтгэлд илүү их цаг зав гарган, хичээлд тогтмол ажиглалт, хэлэлцүүлэг хийх замаар хичээлийн хөтөлбөрөө сайжруулахын тулд хичээлийн судалгааг тогтмол хийж хэвших шаардлагатай байна.

Энэхүү төсөлд боловсролын олон байгууллагын төлөөлөл орж ажилласан нь бие биенээсээ суралцах өргөн боломжийг нээж өгсөн. Төсөлд оролцогчид энэхүү хамтын ажиллагаандаа сэтгэл өндөр байсан.

### Сонгинохайрхан дүүрэг дэх сургалт



Ерөнхий хэсгийн лекц



Төсөлт ажлын багийн сургалт



Нэгдүгээр шатны төсөлд оролцсон загвар сургуулийн “Туршлага сургаж” лекц

### Сургалтын модулийн танилцуулга

Тус төслийн хүрээнд боловсруулж буй сургалтын модулийн талаар танилцуулъя. Сургалтын модулийг дараахи гурван зорилгоор боловсруулж байна.

1. Сургалтанд оролцогчдын боловсролын стандартад суурилсан багшийн арга зүйн шинэчлэл, хичээлийн судалгааны арга зүйн талаархи ойлголтыг гүнзгийрүүлэх.
2. Сургалтанд оролцогчдод арга зүйн шинэчлэл дэх үүрэг оролцооных нь талаар ойлголт өгч, бодитоор хэрэгжүүлэх чадварыг эзэмшүүлэх.
3. Сургалтанд оролцогчид бүх аймаг дүүрэг дэх багшлахуйн арга зүйн шинэчлэлийн тогтолцоог бэхжүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмэр оруулах.

Багшлахуйн арга зүйг шинэчлэхдээ, зөвхөн багш нарын ойлголтыг гүнзгийрүүлэн арга барилыг нь дээшлүүлээд зогсохгүй, сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг чиглэл үзүүлж ажиллах үүрэгтэй Боловсрол соёлын газрын дарга мэргэжилтэн, сургуулийн удирдлага ч арга зүйн шинэчлэлийн талаархи ойлголтоо гүнзгийрүүлэн бүгд хамтран ажиллах явдал зайлшгүй чухал юм. Иймд энэхүү сургалтын модуль нь багшийн модуль (Боловсрол соёлын газрын мэргэжилтэн, багш нарт зориулсан) болон удирдлагын модулиас (Боловсрол соёлын газрын дарга, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, сургуулийн удирдлагад зориулсан) бүрдэнэ.

Энэхүү модульд боловсролын стандарт болон шавь төвтэй сургалтын арга зүйн үзэл баримтлал, судлагдахуун бүрт (Физик, хими, хүн-орчин, хүн-байгаль, бага ангийн математик, дунд ангийн математик, мэдээлэл зүй төсөлт ажил) мэдлэг бүтээлгэх шинэ арга зүйг нэвтрүүлэх аргачлал, “Хичээлийн судалгаа”-г хэрэгжүүлэх арга зүй зэргийг багтаасан. 2010 оны 11 дүгээр сард уг модулийг ашиглан загвар аймаг дүүргийн (СХД, Булган аймаг, Завхан аймаг) БСГ болон загвар сургуулиудад зориулсан сургалт (дор дурьдах) зохион байгуулсан. Энэхүү сургалтад хамрагдсан загвар аймаг дүүрэг, загвар сургуулиудын хичээлийн судалгаа хийж буй байдалд хийсэн мониторингийн дүнг үндэслэн, энэхүү сургалтын модулийг улам сайжруулахаар төлөвлөж байна.

### Булган аймаг дахь сургалт



Дунд ангийн математикийн баг



Бага ангийн математикийн хичээлд ажиглалт хийж байна



Хүн орчин хичээлийн хэлэлцүүлэг

**Завхан аймаг дахь сургалт**



Эхний өдрийн нэгдсэн лекц



Химийн туршилт хичээл



Физикийн хичээлийн туршилт

**Төслийн багийн танилцуулга:**



JICA-гийн төслийн багт дор нэр дурьдах хүмүүсээс гадна орчуулагч Г.Норжмаа, Х.Ганбаатар, жолооч Р.Баттогтох нар ажиллаж байна.

**Хаяг:**

БСШУЯ, Засгийн газрын 3-р байр, 119 тоот  
Бага тойруу-44, Улаанбаатар, Монгол Улс  
Утас/Факс: 976-11-322552, 98900323  
Мэйл хаяг: jicacatm@gmail.com  
Вэбсайт: <http://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/004/index.html>

Иший Тэцүя	Менежмент / Сургалтын төлөвлөгөө 1
Сүзүки Саяака	Сургалтын төлөвлөгөө 2/Мониторинг, үнэлгээ
Камата Масахиро	Арга зүй түгээн дэлгэрүүлэх (байгалийн ухаан)
Такахата Хироши	Арга зүй түгээн дэлгэрүүлэх (бага дунд ангийн математик)
Фүкүчи Аkitэрү	Арга зүй түгээн дэлгэрүүлэх (байгалийн ухаан, төсөлт ажил)
Мацүүра Шюү	Арга зүй түгээн дэлгэрүүлэх (мэдээлэл зүй)
Б.Хишигбаяр	Сургалт зохион байгуулах/Хичээлийн судалгаанд дэмжлэг үзүүлэх

**Сургалтын танилцуулга**

Төслийн баг 2010 оны 11 дүгээр сард загвар аймаг дүүргийн БСГ-ууд болон загвар сургуулиудын төлөөлөлд зориулсан сургалтыг зохион байгууллаа. (СХД: 11 дүгээр сарын 1-5, Булган аймаг: 11 дүгээр сарын 12-16, Завхан аймаг : 11 дүгээр сарын 19-23)

Энэхүү сургалт нь багш удирдлага мэргэжилтнүүдийн суралцахуйд суурилсан арга зүйг сайжруулах болон хичээлийн судалгааны талаархи мэдлэгийг нь гүнзгийрүүлэн, багшлахуйн арга зүйн шинэчлэл дэх багш удирдлага, мэргэжилтнүүдийн үүрэг оролцооны тухай ойлголт өгч, багш нарт хичээлийн судалгааг зохион байгуулах чадварыг олгох зорилготой юм.

Оролцогчидын боловсролын стандарт болон цогц чадамжийн талаархи ойлголтыг гүнзгийрүүлэхийн зэрэгцээ суралцахуйд суурилсан шинэ арга зүйн тухай нэгдмэл ойлголттой болгох зорилгоор сургалтын эхний өдөр нэгдсэн журмаар лекц зохион байгуулсан. Хоёр буюу гурав дахь өдөр хичээл бүрийн сургалтын шинэ арга зүй, түүнчлэн арга зүйг сайжруулах арга зам болох “Хичээлийн судалгаа”-ны тухай танилцуулсан. Дөрөв дэх өдөр туршилтын хичээл заан, ажиглалт хэлэлцүүлэг зохион байгуулан оролцогчид өөрсдөө оролцон “Хичээлийн судалгаа”-ны тухай ойлголтгоо гүнзгийрүүлсэн. Харин тав дахь өдөр нь арга зүйгээ цаашид хэрхэн сайжруулах вэ гэсэн асуудлаар байгууллага сургууль бүр үйл ажиллагааныхаа график төлөвлөгөөг боловсруулан түүнийгээ танилцуулсан.

	Багшийн модуль	Удирдлагын модуль
Зорилтот бүлэг	<ul style="list-style-type: none"> <li>• БСГ-ын мэргэжилтэн</li> <li>• Багш нар</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• БСГ-ын дарга, мэргэжилтэн</li> <li>• Сургуулийн захирал</li> <li>• Сургалтын менежер</li> </ul>
Судалгдахуун	Бага ангийн Математик, Дунд ангийн Математик, Хими, Физик, Хүн-Байгаль, Хүн-Орчин, Мэдээлэл зүй, Төсөлт ажил	
Модуль	1 дэх өдөр	Нийт оролцогчид нэгдсэн журмаар хамрагдана.
	2 дахь өдөр: Үдээс өмнө	<ul style="list-style-type: none"> <li>• Энэхүү сургалтаар олж мэдсэнээ тус тусын сургуульд хэрхэн түгээвэл зохих вэ.</li> <li>• БСГ, сургууль дээр хичээлийн судалгааг хэрэгжүүлэх, хэвшүүлэхэд чиглэсэн төлөвлөгөө боловсруулах</li> <li>• Хичээлийн судалгааг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин ба менежмент</li> </ul>
	Үдээс хойш	“Багшийн модуль”-ийн үйл ажиллагаанд оролцох.
	3 дахь өдөр	“Багшийн модуль”-ийн үйл ажиллагаанд оролцох.
	4 дэх өдөр: Үдээс өмнө	“Багшийн модуль”-ийн үйл ажиллагаанд оролцох.
Үдээс хойш	<ul style="list-style-type: none"> <li>• Хичээлийн хөтөлбөрөө сайжруулах</li> </ul>	БСГ, сургуулийн төлөвлөгөөнд хичээлийн судалгааны төлөвлөгөөгөө тусгах
5 дахь өдөр	<ul style="list-style-type: none"> <li>• БСГ, сургууль тус бүрээр хичээлийн судалгааг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах</li> <li>• Бүх байгууллагуудын танилцуулга, зорилго, зорилт, төлөвлөгөөнийхөө тухай илтгэл тавих</li> </ul>	Бүх оролцогчид нэгдсэн журмаар лекцэд хамрагдана.

**Мэдлэг, үр чадвараа амьдралд бодитоор ашиглах чадвар:**

**“Суралцах чадварын үнэлгээ”-ний дүн**

2009 онд Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллага (ЭЗХАХБ) 65 улс орон, бүс нутгийн 15 настай 470 мянга гаруй сурагчийг хамарсан “Суралцах чадварын үнэлгээ (PISA: OECD Programme for International Student Assessment)”-г зохион байгуулсан ба 2010 оны 12 дугаар сарын 7-нд энэ судалгааны дүнг зарлажээ. Суралцах чадварын үнэлгээ судалгаа нь 3 жил тутам хэрэгждэг бөгөөд 15 настай сурагчдын бага, дунд боловсролоор олж авсан мэдлэг, үр чадвараа амьдралд бодитоор ашиглах чадварыг нь тогтоох зорилгоор хэрэгждэг судалгаа юм. Япончууд “Уншиж ойлгох чадвар”-аар 8-р байр, “Математикийн үүднээс хандах чадвар”-аар 9-р байр, “Шинжлэх ухааны үүднээс хандах чадвар”-аар 5-р байрт шалгарчээ. Эдгээр гурван үзүүлэлтээр Азийн орнуудын сурагчид эхний 10 байрын талаас илүү хувийг эзэлсэн байна.

Суралцах чадварын үнэлгээний шалгуур болох мэдлэг ашиглах чадварт онцгой анхаарах нь дэлхий нийтийн хандлага болж байна. Монголын бага дунд боловсролд хүүхдүүдийн мэдлэг, үр чадвараа ашиглах чадварыг нь хөгжүүлдэг үү? Монголд 15 настай хүүхдийн “Уншиж ойлгох чадвар”, “Математикийн үүднээс хандах чадвар”, “Шинжлэх ухааны үүднээс хариулах чадвар”-ыг хангалттай хөгжүүлж байгаа юу?

Суралцах чадварын үнэлгээний тухай дэлгэрэнгүйг дараахи цахим хуудсаас үзнэ үү.

<http://www.oecd.org/dataoecd/51/27/37474503.pdf>



## Төслийн мэдээлэл 2011 оны 8 дугаар сар №2

### Хичээлийн судалгааны хэрэгжилтийн тайлан

#### Хичээлийн судалгаа

Энэхүү төслөөр “Хичээлийн судалгаа” хэмээх арга зүйг ашиглан, багшийн арга зүйг шинэчлэхээр зорьж байна. Хичээлийн судалгаа нь, 1) Хичээлийн бэлтгэл (Хичээлийн бэлтгэл судалгаа), 2) Хичээл явуулах (Судалгаат хичээл) болон бусад багш нар ажиглалт хийх, 3) Хичээлтэй холбоотой хэлэлцүүлэг гэсэн 3 алхамтай. Хичээл заах багш хичээлд ажиглалт хийсэн бусад багш нараас зөвлөгөө авч, арга зүйгээ сайжруулах боломжтой болно. Мөн, ажиглалт хийх багш нар ч, хичээл явуулах багшийн шинэлэг арга зүй, шалгарсан арга зүйгээс суралцах боломжтой.

Энэхүү хичээлийн судалгааг Японд 100 гаруй жилийн өмнөөс хийж эхэлсэн бөгөөд дэлхийн нийтийн анхаарлыг зүй ёсоор татаж байгаа билээ. Монгол Улсын БСШУЯ хичээлийн судалгааны чухал ач холбогдол өгч, “2010-2011 оны хичээлийн жилийн зорилт”-доо “ЕБС-ийн бүх багш нар хичээлийн судалгааг хэрэгжүүлэх аргачлал, өөрөөр хэлбэл шинэ арга зүйг судлахын зэрэгцээ бүх сургуулиуд хичээлийн судалгаа хийх төлөвлөгөө боловсруулан, энэ хичээлийн жилд 2-оос доошгүй удаа хичээлийн судалгаа хийх” гэж тусгажээ.

#### Загвар сургуулиуд дахь хичээлийн судалгааны хэрэгжилт

Төслийн загвар сургуулиуд 2011 оны 2-3 сард хичээлийн судалгааг зохин байгуулсан.

Мэргэжлийн баг болон төслийн багийн зүгээс 1) 2010 оны 11 сард төслөөс зохион байгуулсан сургалтын үр дүн болон тулгамдсан асуудлыг тодорхойлох, 2) Бүх загвар сургуулиудын хичээлийн судалгаанд зөвлөгөө өгөх зорилгоор мониторинг хийсэн.

“Төслийн мэдээлэл №2”-т, бүх загвар сургуулиудад зохион байгуулагдсан хичээлийн судалгааны явц болон загвар сургуулиудын сэтгэгдлийг толилуулж байна.

#### Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргээс Ирээдүй цогцолбор сургууль, 12-р сургууль, 67-р сургуулиуд тус төслийн загвар сургууль болсон юм.

Ирээдүй цогцолбор сургуулийн 3-р бага сургуулийн төсөлт ажлын хичээлээр, сурагчид өөрсдөө “Ус” хэмээх сэдвийг сонгон авч, уг сэдэвт тохирсон асуудлуудын талаар баг бүр судалгаа хийжээ. Судалгаат хичээл явуулсан явцын тайлангаас, сурагчид “Орон сууцны болон гэр хороолол дахь усны ашиглалтыг харьцуулсан судалгаа” зэрэг сонирхолтой танилцуулгыг хийж, судалгааныхаа явцад багш сайын зөвлөгчийн үүрэг гүйцэтгэж тухай дурьдсан байсан.

67-р сургуулийн химийн судалгаат хичээлээр туршилт явуулж, сурагчдын ажиглалт хийх чадвар, хичээлийн сонирхол, оролцоо дээшилж байгааг тогтоосон. Өнөөг хүртэл хичээлд сорил туршилт явуулах боломж хомс байсны улмаас туршилт хийхэд хүндрэлүүд гарч байлаа. Энэ удаагийн судалгаат хичээл, хичээлийн хэлэлцүүлгээр дамжуулан “Хичээлээр юуг хүүхдүүдэд ойлгуулах”, “Хүүхдийн хариултыг урьдчилан тооцох” нь сурагчдын идэвхитэй үйл ажиллагаанд дэмжлэг болдог болохыг ойлгосон байна.



Математикийн судалгаат хичээлийн явц  
(Сэлэнгэ сумын сургууль)

#### “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”

Монгол Улсын боловсролын салбарт 2005 оноос цогц чадамжид суурилсан бага, дунд боловсролын стандартыг хэрэгжүүлж эхлэсэн билээ. Энэхүү шинэ стандартаар, сурагчдын өөрсдөө мэдлэг бүтээх чадварыг хөгжүүлэх, улмаар багш бүр сургалтын шинэ арга зүйг эзэмших явдал зайлшгүй чухлаар тавигдана.

Иймд, БСШУЯ болон ЖАЙКА хамтран 2010 оны 4 сараас “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж эхэлсэн.

Төслийн зорилго нь “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил (2006-2009)” төслийн хүрээнд боловсруулсан багшид зориулсан зөвлөмж, эдүгээ боловсруулж буй сургалтын модулийг ашиглан суралцахуйд суурилсан багшлах арга зүйг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх бүтэц, тогтолцоог бэхжүүлэх явдал юм.

Тус төслийг МУИС, МУБИС, Боловсролын хүрээлэн болон өмнөх төслийн холбогдох хүмүүсээс бүрдсэн “Мэргэжлийн баг” загвар аймаг, дүүрэг болох Сонгинохайрхан дүүрэг, Булган аймаг, Завхан аймагтай хамтран хэрэгжүүлж байна.

#### Гарчиг:

Хичээлийн судалгааны хэрэгжилтийн тайлан	1-2
“Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”	1
Хичээлийн судалгаа хэрэгжүүлэх сургалт семинар зохион байгуулав	2
Төслийн зөвлөх багш нарын өгсөн зөвлөмж	3
Цаашдын төлөвлөгөө	4
Төслийн зохицуулагчийн танилцуулга	4
Төслийн багийн талархал	4
Төслийн багийн холбоо барих хаяг	4



**Булган аймаг**

Булган аймагт 1-р сургууль, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Гурванбулаг сумын сургууль зэрэг нийт 5 сургууль загвар сургуулиар ажиллаж байна.

Хишиг-Өндөр сумын сургуулийн “Хүн байгаль” судалгаат хичээлд мөн сорил туршилт зохион байгуулсан. Ажиглалтаар дамжуулан дүгнэлт гаргахад хүүхдүүдийг сургахаар зорьсон. Туршилтын хэрэглэгдэхүүн дутмаг байгаа ч, гарын доорхи материалаар туршилтын хэрэглэгдэхүүн хийх зэргээр санаачлага гарган ажиллаж байна. Энэ удаагийн хичээлийн судалгаагаар дамжуулан аюулгүй ажиллагааг хангахын чухлыг ойлгож авчээ.

**Завхан аймаг**

Завхан аймагт Чандмань Эрдэнэ цогцолбор сургууль, Тосонцэнгэл, Сонгино, Баянтэс, Завханмандал, Шилүүстэй сумын сургууль зэрэг нийт 6 сургууль загвар сургуулиар ажиллаж байна.

Сонгино сумын сургуулийн “Хүн орчин” судалгаат хичээлээр сурагчдын өмнөх ойголт мэдлэгт тулгуурлан хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэсэн. Энэ удаагийн туршлагаас, хичээлдээ сайтар бэлтгэж чадвал, хичээл үр дүнтэй болохыг ойлгож авсан. Хичээлийн судалгаа нь багш нар, багш сурагчид, тэрчлэн сурагчид бие биенээсээ суралцах боломжийг буй болгодог. Хичээлийн судалгаанд оролцсон багш нар өөрсдийнхөө арга зүйг сайжруулах чин эрмэлзэлтэй болжээ.

Шилүүстэй сумын сургуулийн “Мэдээлэл зүй” судалгаат хичээлээр, өдөр тутам идэвхи султай сурагчид ч хичээлд идэвхитэй оролцож байгаа нь ажиглагдсан. Өнөөг хүртэл зохион байгуулж ирсэн нээлттэй хичээлээр багш бүгдийг ганцаараа хийдэг

байсан. Харин хичээлийн судалгаанд олон багш нар хамтран хичээлд бэлтгэдэг. Мэдээлэл зүйн хичээлийг явуулсан багш “Хичээлийн бэлтгэлээр дамжуулан, туршлагатай багш нараас суралцсан” гэж дурсжээ. Мэдээж, хичээл тэр чигээрээ төлөвлөгдсөний дагуу явагдаж чадаагүй. Гэхдээ цаашдын хичээлүүдийг улам сайжруулахад туршлага болох үүднээсээ энэ удаагийн хичээл нь туйлын ач холбогдолтой болсон байна.

**Хичээлийн судалгааны үр дүн ба тулгамдсан асуудал**

Энэ удаагийн хичээлийн судалгаагаар дамжуулан, ихэнхи загвар сургуулиуд дараахи үр дүд хүрсэн хэмээн тайлагнажээ.

- Хичээлийн бэлтгэл чухал болохыг ойлгож эхэлсэн.
- Багш нар хамтран хичээлээ бэлтгэж, харилцан бие биендээ зөвлөснөөр их зүйлийг сурч мэдсэн.
- Хүүхдүүдийн өмнөх мэдлэгт тулгуурлан хичээлээ бэлтгэх, хүүхдийн хандлагыг тооцохын чухлыг ойлгосон.
- Багшийн арга зүй өөрчлөгдсөнөөр хүүхдүүдэд ч өөрчлөлт ажиглагдаж байна. (Хичээлд идэвхитэй оролцон, багаар ажиллах чадвар дээшилсэн зэрэг)

Нөгөө талаар дараахи хүндрэлүүд ч гарч байна.

- Хичээлийн бэлтгэлд цаг хугацаа их шаардаж байна.
- Ижил мэргэжлийн багш нар цөөн тул мэргэжлийн зөвлөгөө авахад хүндрэлтэй.
- Туршилтын хэрэглэгдэхүүн дутмаг.

Бүх сургуулиуд гарын доорхи материалаар туршилтын хэрэглэгдэхүүн хийх зэргээр янз бүрийн санаачлага гарган, хүндрэлийг даван туулж байсан. Мөн, сургуулийн захирал, сургалтын менежерүүдийн идэвхитэй хамтын ажиллагаа хичээлийн судалгаанд зайлшгүй чухал байлаа.



Баянтэс сумын сургуулийн захирлын танилцуулга



Багын математикийн багийн ажил



Төслийн зөвлөх багшийн лекц

**Хичээлийн судалгааг хэрэгжүүлэх сургалт семинарыг зохион байгуулагдлаа**

2011 оны 6 сарын 2-4-нд, загвар аймаг, дүүргийн холбогдох хүмүүс, мэргэжлийн багийн гишүүд зэрэг 100 гаруй багш нар цуглан, хичээлийн судалгааг хэрэгжүүлэх сургалт семинарыг зохион байгууллаа.

Семинарын эхний өдөр, бүх аймаг, дүүрэг дэх багшлахуйн арга зүйн шинэчлэлийн талаар танилцуулга хийгдэж, хичээлийн судалгааг хэрэгжүүлснээр багш сурагчдад гарч буй эерэг өөрчлөлт, цаашдын тулгамдсан асуудлуудын талаар санал бодлоо солилцов. 2 дахь өдөр, төсөлд 1-р шатнаас эхлэн оролцож байсан багш нар судалгаат хичээл зохион байгуулж, оролцогчид саналаа идэвхитэй солилцсон. Сүүлийн өдөр, төслийн зөвлөх багш нар “Бага дунд боловсрол дахь хичээлийн судалгааны ялгаа”, “Хүүхдийн суралцах чадварыг хэмжилт хийх аргаар илрүүлэх нь” сэдвээр лекц уншсаны дараа, загвар аймаг дүүргүүд 2011-2012 оны хичээлийн жилд багшлахуйн арга зүйгээ шинэчлэх төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулсан.

Семинарт оролцогчдын илтгэлүүдэд, хичээлийн судалгааг хийснээр багш төдийгүй сурагчдад ч өөрчлөлт гарч буйг анзаарч эхэлж буй тухай дурьдагдаж байлаа. “Хүүхэд хичээлдээ сонирхолтой болсон”, “Өөрийн санаа бодлоо илэрхийлж чаддаг болсон” гэх зэргээр саналаа хэлж бйасан юм.

Түүнчлэн, уг семинарт Улаанбаатар хот, Булган аймаг, Завхан аймгийн төслийн холбогдох хүмүүс анх удаа нэг дор цуглан уулзацгаасан юм. Тус тусын олсон ололт амжилт, туршлага, гарч буй хүндрэлүүдийн талаар ярилцсан нь багш нар өөр хоорондоо дэм өгөх сайхан боломж болжээ.

## **Хичээлийн судалгаанд төслийн зөвлөх багш нараас өгсөн зөвлөмж**

Хичээлийн судалгааны ач холбогдолыг улам бүр дээшлүүлэх зорилгоор төслийн зөвлөх багш нарын хэд хэдэн зөвлөмжийг толилуулж байна.

### 1. Хичээлийн судалгаанд нийцэхүйц хичээл

Хөндлөнгийн ажиглагч оролцуулсан судалгаат хичээлээр ажиглагч дараахи зүйлүүдийг сурч мэдэхүйц судалгаат хичээлийг явуулах шаардлагатай.

- Хичээлийг удирдан явуулахад олон арга байж болохыг анзаарч ойлгох.
- Хүүхдийн чадвар хөгжиж буйг анзаарч мэдэх.
- Хичээлд ямар хэрэглэгдэхүүн ашиглах боломжтой болох талаар ойлголтоо гүнзгийрүүлэх.
- Хүүхдийн бодол санааг олж харах чадвар дээшлэх.

Дээрхи зүйлүүдийг суралцах боломжтой хичээл гэдэг нь, шинэлэг ойлголт, шинэлэг бодол санаа, шинэлэг үзэгдлийг тусгасан хичээл, хүүхдүүдийн сэтгэн бодох чадварыг дээшлүүлэн асуудлыг шийдвэрлэх хичээл, хүүхэд болон багш, хүүхдүүд хоорондын харилцаанаас хүүхэд өсөж хөгжиж байгаа нь харагдахуйц хичээл юм.

Өөрөөр хэлбэл, ердийн хичээлийг дахин давтан орох, зүгээр л тоо бодон дасгал ажиллах, шалгалт авах, ном унших төдийхний хичээлийг судалгаат хичээл гэж үзэх боломжгүй. Хичээлийн судалгаа хийх өдөр иймэрхүү хичээл таарсан тохиолдолд, хөтөлбөртөө зохицуулалт хийх шаардлагатай.

### 2. Судалгаат хичээлийн суралцагч

Багш болж өгвөл өөрөө өдөр тутам хичээл заан, түвшин, чадвар, зан төлөвийг нь сайтар мэддэг хүүхдүүдэд хичээл заавал зохино. Энэ нь хүүхдүүдийг хичээлд бүрэн хамруулж, бүгдийг нь хөгжүүлэхийн тулд хичээлийн явцад хүүхэд тус бүрийн түвшин, чадвар, зан төлөвт тохирсон асуулт тавьж, илтгэл тавиулах шаардлагатай байдгаас тэр юм.

### 3. Хичээлийн хөтөлбөр

Хичээлийн бэлтгэл бол туйлийн чухал хичээлийн судалгааны процесс юм. Хичээл төлөвлөхдөө хичээлийн сэдвээ сайтар базах нь чухал. Жишээ нь, байгалийн ухааны ээлжит хичээлээр 3-4 туршилт хийх боломжгүй.

Хичээлийн хөтөлбөрт, хүүхдийг ажиглахтай (өөрөөр хэлбэл, хүүхдийн өдөр тутмын туршлага, хэдийн суралцсан зүйл, өмнөх хичээлийн агуулга) холбоотой тайлбар шаардлагатай болно. Тухайн цагийн хичээлээр “Ямар байсан хүүхэд (Хичээл эхлэхийн өмнөх хүүхдийн төлөв)”-ийг “Ямар хүүхэд (Хичээлийн дараахи хүүхдийн төлөв)” болгон өөрчлөхөө тодорхой тусгах нь зүйтэй.

### 4. Хичээл явуулах

#### 1) Мэдээллийн хэрэгсэл ашиглах:

Энгийн хичээлд проектор ашигладаггүй байснаа зөвхөн судалгаат хичээлийн үеэр хүчээр ашигладаг гэх мэт асуудал байгаа болов уу? Мэдээллийн хэрэгслийг ашиглахдаа, түүнийг хичээлд ашиглах зайлшгүй хэрэгцээ бий эсэхийг сайтар нягтлах шаардлагатай.

#### 2) Самбар ашиглалт

Японы бага сургуулиудад, ээлжит хичээлийн явцад багш дахин дахин самбарт юм бичиж арчаад байдаггүй.

Самбарт бичигдсэн зүйлийг хүүхдүүд дэвтэртээ буулгахад, дэвтрээсээ тухайн цагт үзсэн зүйлээ мэдэж болохуйцаар төлөвлөн бичигдсэн байдгаас тэр юм.

Хичээлийн судалгаанд самбар ашиглалт туйлийн чухлаар тавигдана. Ажиглагч тухайн самбарын бичиглэлийг хараад, багшийн санааг олж мэдэх боломжтой. Нөгөө талаар, хичээл зааж буй багшийн хувьд ч урьдчилан самбар ашиглалтаа төлөвлөснөөр өөрийнх нь хичээлийн төлөвлөгөө тодорхой бөгөөд ойлгомжтой болж, юуг сайжруулах шаардлагатайгаа олж харахад хялбар болно.

#### 3) Хүүхдийг урамшуулах

Хичээлийн явцад хүүхдүүдийг урамшуулж буй хичээл ч байдаг бололтой. Энэ нь хүүхдийн сурах хүсэл сонирхолыг дээшлүүлэх аргынхаа хувьд үнэхээр тохиромжтой арга мөн үү? Өөрөөр хүүхдийн сурч мэдэх хүслийг дээшлүүлэх арга байх л ёстой. Ердийн үед сурагчдаа ажиглаж байвал, ямар үед юуг нь магтаад өгвөл үр дүнтэй болохыг ойлгоно.

#### 4) Цаг хуваарилалт

Хичээлийг цагтаа багтаан дуусгах нь үндсэн зарчим хэдий ч, төлөвлөснийхөө дагуу хичээлээ явуулах гэж хэт хичээх нь “Хүүхэд төвтэй” багшлах арга зүйд тэр бүр нийцэх муутай. Тухайн нөхцөлд хүүхдийнхээ төлөв байдлыг ажиглан, түүнд нь тохируулан цаг хуваарилалтаа өөрчилж чадаж байваас сая “Хүүхэд төвтэй” болно.

### 5. Хичээлийн ажиглалт

#### 1) Ажиглагчийн үүрэг

Хичээлийн ажиглалтыг хийхдээ, болж өгнвөл ажиглагчийн үүргийг ангилахгүй байх нь дээр. Зөвхөн нэг л зүйлийг ажиглах бус, хичээлийн ерөнхий явцыг харах хэрэгтэй. Хичээлийн ерөнхий явцыг ажигласнаар хичээл сайн муу болсныг мэдэж авахын зэрэгцээ ажиглагч өөрөө шинэ зүйл сурч мэдэх боломжтой болно.

Тодорхой нэг хүүхдийг анхааран ажиглахдаа зорилгоо тодорхой болгох.

#### 2) Ажиглалтын харалт

Багш хичээлийн судалгааныхаа сэдвийг ажиглагч багш нарт урьдчилан хэлж, ямар зүйл дээр анхааран ажиглалт хийлгэмээр байгаагаа тодорхой болговол зүгээр. Мөн, юу юунаас илүү хүүхдийн хандлагыг анзаарах хэрэгтэй. Хүүхдүүдийн царайг харж болохуйц байрлалаас ажиглалт хийх нь гол үндэс болно.

#### 3) Ажиглалтаар оноо өгөх тухай

Японы сургуулиудын хичээлийн судалгаанд багшид оноо өгөх маягаар багшийг үнэлдэггүй.

### 6. Хичээлийн хэлэлцүүлэг

Хичээлийн дараахи хэлэлцүүлгийг тухайн хичээлийг явуулсан танхимд зохион байгуулах нь хамгийн тохиромжтой. Хичээлд ашигласан самбар болон үзүүлэн, туршилтын хэрэглэгдэхүүнийг байлгахад яриа идэвхитэй өрнөж, сайжруулбал зохих зүйлүүдийг онцлон ярилцахад хялбар болно.

**Япон багш нар хэр завгүй  
ажилладаг вэ ?**

Японы бага сургуулийн багш нар 7 хоногт дунджаар 18.8 цаг, дунд сургуулийн багш нар 14.6 цагийн хичээл заадаг байна (7 хоногийн нийт ажлын цаг нь 40 цаг). Монгол багш нартай харьцуулахад, хичээлийн цаг багатай мэт санагдаж болох юм.

Багшийн ажил бол зөвхөн хичээл заах явдал биш. Хичээлийн бэлтгэл судалгаа гэх мэтээр тухайн хичээлийг заахад бэлтгэх, шалгалтын асуулт боловсруулах болон сурлагын дүнг тооцох, хүүхдүүдийг сургууль дээр байх үед хичээлээс гадуурхи үйл ажиллагаа, секц дугуйлан ажиллуулах, аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээдэг. Мөн, эцэг эхийн хурал, сургуулийн арга хэмжээ, багш ажилтны хуралд оролцохоос гадна сургуулийн захиргаа, сургалтын зөвлөлд тайлан боловсруулж өгөх зэрэг янз бүрийн ажил үүргийг хүлээдэг байна.

Олонхи багш нар хурал цуглаан, тайлан бичихэд цагаа зарцуулан, бага ч атугай хүүхдүүдээ цаг зав гаргахыг эрмэлздэг байна. Монголын багш нарын хувьд ямар байдаг вэ?

Япон Улсын Боловсрол, Шинжлэх ухааны Яамны “Багш нарын статистик судалгаа”-наас (Тоо баримт нь 2010 оны 10 сарын 1-ний байдлаар)



Энэхүү төслийн мэдээллийг Монголын уншигчдад зориулав.

**Цаашдын төлөвлөгөө****МУБИС-ийн багш нарт зориулсан “Хичээлийн судалгаа”-ны арга зүйг танилцуулах сургалт**

Төслийн баг, БСШУЯ болон МУБИС-тай хамтран 2011 оны 8 сарын 29-30-нд МУБИС-ийн харьяа 12 дээд сургуулийн удирдлага, багш нарт зориулсан “Хичээлийн судалгаа”-ны арга зүй, сургалтын модулийг танилцуулах зорилгоор сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна.

**Суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх сургалт**

Бүх аймаг, дүүргийн БСГ/БХ болон загвар сургуулиудад зориулан, 1) Суралцахуйд суурилсан багшлах арга зүй, хичээлийн судалгааны талаархи мэдлэгийг нь гүнзгийрүүлэн, 2) Арга зүйн шинэчлэл дэх удирдлага, багшийн үүрэг оролцоог тодорхойлж, 3) Хичээлийн судалгаа хийх чадварыг хөгжүүлэх зорилгоор сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн.

Сургалтыг 2011 оны 11 сард, Улаанбаатар хот (2 газар) болон Булган, Завхан, Сэлэнгэ, Дорнод аймгуудад зохион байгуулна.

Багшлахуйн арга зүйн шинэчлэлийг цаашид үргэлжүүлэн хэрэгжүүлэх явдал туйлын чухал. Төслийн баг цаашид ч, мэргэжлийн багтай хамтран Монгол Улсад багшлахуйн арга зүйн шинэчлэх үйлсэд тодорхой дэмжлэг үзүүлэн ажиллах болно.

**Төслийн зохицуулагчийн танилцуулга**

2011 оны 6 сараас эхлэн төслийн зохицуулагчаар МУИС-ийн Хими, Хими технологийн сургуулийн багш, Мэргэжлийн дидактикийн сургалт, судалгааны төвийн захирал Н.Оюунцэцэг томилогдон ажиллаж байна.

***Төслийн зохицуулагчийн мэндчилгээ:***

Боловсролын салбарт олон тооны төсөл хэрэгжиж байгаа боловч, тус төсөл нь багшийн арга зүйг өөрчлөх, сургууль төвтэй багш нарын мэргэжил дээшлүүлэх тогтолцоог буй болгоход чухал үүрэг гүйцэтгэж байгаагаараа онцлогтой. Өмнөх төслийн талаар та бүхэн хангалттай мэдээлэлтэй байгаа (8 судлагдахууны зөвлөмж боловсруулсан). Энэ удаагийн төслийн эхний жилд загвар аймаг, дүүргийн сургуулиудын удирдлага, багш нарт зориулсан хичээлийн судалгааны арга зүйн сургалтыг зохион байгуулж, энэ чиглэлээр Япон Улсад зохион байгуулдаг сургалтад мэргэжлийн багаас 8, ЖАЙКА-ийн бусад сургалтад 18 багш, мэргэжилтэн сургалтад хамрагдаж ирээд, төслийн үйл ажиллагаанд идэвхитэй хамтран ажиллаж байна. Төслийн 2 дахь жилд, нийт 38 багш, мэргэжилтэн сургалтад хамрагдахаар Япон орныг зорих гэж байна. Мөн, хичээлийн судалгааны арга зүйг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх шаталсан сургалтууд энэ оны 11 сараас эхэлнэ.

Суралцахуйд суурилсан багшлах арга зүйн шинэчлэлд чухал үүрэгтэй хичээлийн судалгааны аргыг хөгжүүлэх тогтолцоо бэхэжсэнээр багш нарын арга зүйн шинэчлэл шинэ шатанд гарна гэдэгт бүрэн итгэлтэй байна.

**Төслийн багийн талархал**

2011 оны 3 сарын 11-нд, Япон Улсад тохиолдсон Зүүн Японы их газар хөдлөлтийн дараа тус төслийн загвар сургуулиуд, түүнчлэн Монголын боловсролын салбарыг төлөөлөх олон тооны багш нар харамгүй хандив тусламж, халуун дулаан урмын үг хайрласан билээ. Энэхүү завшааныг тохиолдуулан, эдгээр бүх хүмүүст гүн талархал илэрхийлье.



**Төслийн  
багийн холбоо  
барих хаяг:**

Өрөө 119, Засгийн газрын 3-р байр,  
Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам  
Багатойруу-44, Улаанбаатар хот, Монгол Улс

Утас/Факс: 976-11-322552

Е-мэйл хаяг: <[jicacctm@gmail.com](mailto:jicacctm@gmail.com)>

Вебсайт:

<http://www.jica.go.jp/project/monglian/mongolia/004/index.html>



## Төслийн мэдээлэл 2011 оны 12 дугаар сар №3

### Багшлахуйн арга зүйн хөгжлийг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх бүсчилсэн сургалтын тайлан

#### Сургалт зохион байгуулсан бүс

2011 оны 11 сард “Багшлахуйн арга зүйн хөгжлийг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх бүсчилсэн сургалт”-ыг доорхи хүснэгтэд дурьдах 6 бүсэд амжилттай зохион байгууллаа.

Сар өдөр	Сургалтын байр	Оролцогчид
1-5/XI	СХД-ийн Ирээдүй ЦС	Нийслэлийн 6 дүүргийн төлөөлөл
10-14/XI	БЗД-ийн 85-р сургууль	Нийслэлийн бусад 3 дүүрэг болон 4 аймгийн төлөөлөл
11-15/XI	Булган аймгийн 1-р сургууль	Булган аймгийн загвар сургуулиуд болон Хангайн бүсийн 3 аймгийн төлөөлөл
11-15/XI	Завхан аймгийн Чандмань-Эрдэнэ ЦС	Завхан аймгийн загвар сургуулиуд болон баруун бүсийн 4 аймгийн төлөөлөл
11-15/XI	Дорнод аймгийн Хан-Уул ЦС	Дорнод аймаг болон зүүн бүсийн 2 аймгийн төлөөлөл
12-16/XI	Сэлэнгэ аймгийн 1-р сургууль	Сэлэнгэ аймаг болон төвийн бүсийн 3 аймгийн төлөөлөл

Уг сургалтыг, мэргэжлийн багийн гишүүдээс гадна 2011 оны 10 сарын 21-22-ны сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдсан НБГ болон Булган, Завхан, Дорнод, Сэлэнгэ аймгийн БСГ-ын мэргэжилтнүүд удирдан явуулж, нийт 595 оролцогч хамрагдсан.

#### Сургалтын хөтөлбөр

Энэхүү сургалт нь “Суралцахуйд суурилсан багшлах арга зүй”, багшлахуйн арга зүйн шинэчлэлийн арга хэрэгсэл болгон “Хичээлийн судалгаа”-ны арга зүйд суралцуулах замаар үндэсний хэмжээнд “Суралцахуйд суурилсан багшлах арга зүй”-г түгээн дэлгэрүүлэх гол

цөм боловсон хүчнийг бэлтгэх явдлыг энэхүү сургалт үндсэн зорилгоо болгосон юм.

Сургалтын эхний өдөр оролцогчдын Монгол Улсын Боловсролын салбарын шинэчлэлийн талаархи ойлголтыг гүнзгийрүүлэхийн зэрэгцээ “Суралцахуйд суурилсан багшлах арга зүй”, багшлахуйн арга зүйн шинэчлэлийн арга зам болгож “Хичээлийн судалгаа”-ны тухай, мөн тус төслийн туршлага, сургамжийн талаар танилцуулсан.

Сургалтын 2-3 дахь өдөр, судлагдахуун тус бүрээр “Суралцахуйд суурилсан багшлах арга зүй”, “Хичээлийн судалгаа” хийх аргачлалын талаархи ойлголтыг нь гүнзгийрүүлэх зорилго бүхий лекц, дадлага ажлуудыг зохион байгуулсан. Удирдлага, мэргэжилтнүүд багш нартай хамт ажиллахын зэрэгцээ сургагч багш нар болон бусад оролцогчдод “Арга зүйн шинэчлэл дэх удирдлагад тулгамдаж буй хүндрэлтэй асуудал”-ын талаар мэдээлэл өгөх, тус төслийн 1, 2 дахь шатанд арга зүйн шинэчлэлд оролцсон мэргэжилтэн, сургуулийн удирдлагуудын арга туршлагаас суралцах бололцоогоор хангасан.

Сургалтын 4 дэх өдөр, судлагдахуун бүрээр судалгаат хичээл зохион байгуулсан. Сургалт явуулсан сургуулийн зүгээс сурагчдын амралтын үеэр судалгаат хичээл заах ангийн сурагчдыг бэлэн байлгах ажлыг зохион байгуулж, оролцогчид хамтран боловсруулсан хичээлийн хөтөлбөр ашиглан хичээлийг явуулсан. Оролцогчид судалгаат хичээл удирдах, ажиглалт хийх, хэлэлцүүлэгт оролцох зэрэг хичээлийн судалгааны алхмуудыг бодитойгоор хийж гүйцэтгэв.

Сургалтын 5 дахь өдөр, аймаг, дүүргийн баг бүр боловсруулсан үйл ажиллагааны төлөвлөгөөгөө танилцуулан, цаашид ч сургагч багш болон оролцогчид арга зүйн шинэчлэлд хамтран ажиллах тухайгаа хэлэлцэн тохирч, сургалтын үйл ажиллагаа өндөрлөв.

#### “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”

Монгол Улсын боловсролын салбарт 2005 оноос цогц чадамжид суурилсан бага, дунд боловсролын стандарт, 2008 оноос Сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн билээ. Эдгээр шинэ стандарт, хөтөлбөрт сурагчдын өөрсдөө мэдлэг бүтээх чадварыг хөгжүүлэх, улмаар багш бүр сургалтын шинэ арга зүйг эзэмших явдал зайлшгүй чухлаар тавигдаж байна.

Иймд БСШУЯ болон ЖАЙКА хамтран 2010 оны 4 сараас “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж эхэлсэн.

Төслийн зорилго нь “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил (2006-2009)” төслийн хүрээнд боловсруулсан багшид зориулсан зөвлөмж, эдүгээ боловсруулж буй сургалтын модулийг ашиглан сургалт зохион байгуулж, суралцахуйд суурилсан багшлах арга зүйг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх бүтэц, тогтолцоог бэхжүүлэх явдал юм.

Тус төслийг МУИС, МУБИС, Боловсролын хүрээлэн болон төслийн 1 дэх шатанд оролцсон хүмүүсээс бүрдсэн “Мэргэжлийн баг” загвар аймаг, дүүргээр сонгогдсон СХД болон Булган, Завхан аймгуудтай хамтран хэрэгжүүлж байна.

#### Гарчиг:

Багшлахуйн арга зүйн хөгжлийг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх бүсчилсэн сургалтын тайлан	1-2
Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл	1
Багш бэлтгэдэг их дээд сургуульд зориулсан сургалт зохион байгуулах	2
Дунд хугацааны үнэлгээний багийг хүлээн авав	2
Хоёр дахь удаагийн хичээлийн судалгааны мониторинг	2
Кёозай кэнкюү гэж юу вэ?	3
Японд сургалт зохион байгуулав	4
Хүрээлэн буй орчны боловсрол гэж юу вэ?	4
Цаашдын төлөвлөгөө	4



“Хөлийнхөө мөрийг ажиглая”  
сэдэвт судалгаат хичээл  
(Хүн байгаль)

Сургалтад хамрагдсан сургагч багш нар болон оролцогчдыг өөр хоорондоо орон нутаг, албан тушаал үл харгалзан харилцан хамтарч ажиллах бололцоог хангах үүднээс энгэрийн зүүлт хэрэглэсэн.



Эдгээр энгэрийн зүүлтийг “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхийн холбоо”-ны гишүүн эхчүүд урлаж өгсөн юм. Монголын бүх хүүхэд сайн боловсрол эзэмших боломж нөхцлөөр хангагдахыг төслийн багийн зүгээс хүсэн ерөөе.



### Сургалтын эргэн тойронд

Сургалтын үед анзаарагдсан сониноос дуулгая.

- Оролцогчдын дунд, өмнө нь хичээлийн судалгааны тухай сонсож байсан, эсвэл өөрөө хийж үзсэн гэх хүн цөөнгүй байсан ч, сургалтад хамрагдсанаар “Хичээлийн судалгааны талаархи хуучин ойлголт маань хангалтгүй байсныг ойлгосон”, “(Өөрийн аймаг, дүүрэгтээ хариад) Сургалтаар олж мэдсэн зүйлээ бодитоор хэрэгжүүлнэ” гэх яриа олонтаа сонсогдож байлаа.
- Сургалт 8 судлагдахуунаар зэрэг явагдсанаар, судлагдахуун хоорондын уялдаа холбоо ч тодорхой хэмжээгээр сайжирсан. Жишээ нь, Хүн байгаль баг “Даралт” сэдэвт нэгж хичээлээр судалгаат хичээл зохион байгуулахдаа Физикийн сургагч багшаас дунд ангид Физикийн хичээлээр уг сэдвийг хэрхэн заадаг, бага ангид хэрхэн заавал болох тухай зөвлөгөө авч байсан.
- Сургагч багш-оролцогч, оролцогчид хооронд гэсэн харилцан сүлжээ үүсэх боломж ч бүрдсэн. Багш нар хоорондоо утас хаягаа солилцож, сургалт зохион байгуулсан аймаг, бүсийн багш нар дунд зэргэлдээх аймгуудын сургалтад сургагч багшаар ажиллах хүсэлтээ илэрхийлсэн хүмүүс ч олон байлаа.
- Мэргэжлийн багийн гишүүдээс гадна тухайн загвар аймаг, загвар сургуулийн багийн гишүүд (мэргэжилтэн, удирдлага, багш нар) сургагч багшаар ажилласан учир сургалт улам үр дүнтэй болсон. Загвар бус аймаг, дүүргийн оролцогчдын хувьд төслийн загвар аймаг, дүүргийн багш нар арга зүйгээ хэрхэн шинэчлэж буйг хараад, нэн даруй өөрсдөө арга зүйн шинэчлэл хийх ёстой гэдгээ ойлгосон харагдаж байлаа.

### Цаашдын тулгамдсан асуудал

Суралцахууд суурилсан багшлах арга зүйг хэвшүүлэх, арга зүйн шинэчлэлийн арга хэлбэр болгож хичээлийн судалгааны арга зүйг танилцуулах, үндэсний хэмжээний арга зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх гол цөм болсон боловсон хүчин бэлтгэх зэрэг зорилгоо сургалт тодорхой хэмжээнд биелүүлсэн гэж үзэж байна. Гэвч бүх аймаг, дүүргийн хэмжээнд суралцахууд суурилсан багшлах арга зүйг зохион байгуулахад 5-хан өдрийн сургалт хангалтгүй юм. Цаашид ч үргэлжлүүлэн хичээж ажиллах шаардлагатай.

5 өдрийн сургалтад хамрагдсан оролцогчид өөрийн аймаг, дүүрэгтээ эсвэл сургууль дээрээ арга зүй шинэчлэх сургалтыг төлөвлөн зохион байгуулж чадна гэсэн бодолтой байсан. Гэхдээ, бодит байдалд сургалтын хөтөлбөр, лекц боловсруулж бэлтгэхэд янз бүрийн асуудал гарахыг үгүйсгэхгүй. Асуудлаа шийдвэрлэхийн тулд эхлээд төслийн баг болон мэргэжлийн баг, төслийн загвар аймаг, дүүргийн БСГ/БХ-г хандахыг зөвлөө.

### **Багш бэлтгэдэг их дээд сургуульд зориулсан сургалт зохион байгуулав**

2011 оны 8 сарын 29-30-нд БСШУЯ, МУБИС-тай хамтран багш бэлтгэдэг улсын болон хувийн их дээд сургуулиудын багш нарт зориулсан сургалт зохион байгуулав. Энэхүү сургалтын зорилго нь, хичээлийн судалгааны аргачлал болон төслийн хүрээнд боловсруулж буй сургалтын модулийг эдгээр их дээд сургуулийн үйл ажиллагаанд ашиглах боломжийг эрэлхийлэх явдал байлаа.

Уг сургалтын үеэр багш нар “Суралцахууд суурилсан багшлах арга зүй болон хичээлийн судалгааны талаар илүү их мэдээлэл авахыг хүсч байна” гэгцгээж байсан юм. Цаашид ч Монгол Улсын хэмжээнд багшлах боловсон хүчин бэлтгэж буй их дээд сургуулиудад дээр дурьдсан мэдээллийг олгохоор төлөвлөж байна.

### **Дунд хугацааны үнэлгээний багийг хүлээн авав**

ЛСА байгууллагаас төсөл хэрэгжүүлэх явцад, төслийн тохиромжтой байдлыг дахин судалж үзэхийн хамт үр дүнтэй байдал, үр өгөөжтэй байдал зэргийг тооцох замаар төслийн зорилго зорилт биелэгдэх магадлалыг тодорхойлох зорилготой “Дунд хугацааны үнэлгээ”-г хийдэг. Дунд хугацааны үнэлгээгээр төслийн хөгжүүлэгч хүчин зүйл, бэрхшээлтэй хүчин зүйлүүдийг мөн тодруулж, үнэлгээнийхээ үр дүнг төсөл хэрэгжүүлэх сүүлчийн хагас хугацааны төлөвлөгөөг сайжруулахад ашигладаг байна.

2011 оны 9 сарын 4-22-нд “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”-д дунд хугацааны үнэлгээ хийсэн. Тус төслийн тохиромжтой байдал болон үр өгөөжтэй байдал нь өндөр гэсэн үзүүлэлттэй гарсны нөгөөтэйгүүр, “Бүх аймаг, дүүргийн БСГ/БХ-ийн зүгээс багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын тогтолцоог ашиглах замаар багш нарт шинэ арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлнэ” гэсэн төслийн зорилгоо биелүүлэхийн тулд хэд хэдэн тулгамдсан асуудлыг тодорхойлж гаргасан. Төслийн загвар аймаг, дүүрэг болон бусад аймаг, дүүргүүдийн хүний нөөцийг хөгжүүлэх, арга зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх тогтолцоог бэхжүүлэхэд (Мэргэжлийн багийг зохион байгуулалтад оруулах) чиглэсэн дэс дараатай ажил зохион байгуулах шаардлагатай гэдэг нь харагдаж байна.

## Хоёр дахь удаагийн хичээлийн судалгааны мониторинг



Хүүхэд шинийг олж мэдэн, сэтгэн бодох боломжтой хичээлийг зохион байгуулж чадаж байна уу?

2011 оны 9 сарын дундаас 10 сарын дунд хүртэлх хугацаанд Улаанбаатар хот болон Булган, Завхан аймгийн загвар сургуулиудын хичээлийн судалгааны явцтай танилцах зорилгоор мониторинг хийсэн.

Уг мониторингоор дамжуулан олон тооны туршилттай хичээл, амьдралтай холбосон хичээлүүдэд ажиглалт хийх боломж олдсон. Энэ үеэр төслийн загвар сургуулиудад тойргийн бусад сургуулиудаас нь багш нар ирж, судалгаат хичээлийг үзэн сонирхож байлаа. Нөгөөтэйгүүр, хичээл удирдсан багш нь ажиглагч багш нарт хичээлээ үзүүлэхэд л анхаарлаа хандуулаад, хүүхэд нэг бүрийн хэрхэн сурч, хичээлээ хэрхэн ойлгож буйг хангалттай анхаарч чадахгүй байсан хичээл ч цөөнгүй тохиолдож байв.

Хичээлийн судалгааг үргэлжлүүлэн хийснээр багш нар бие биенээсээ суралцах орчин бүрдэнэ гэдэгт найдаж байна.

### Кёозай кэнкюү гэж юу вэ?

“Кёозай Кэнкюү” буюу “Хичээлийн бэлтгэл судалгаа”-г дан ганц 40 минутын хичээлд бэлтгэх зорилготой үйл ажиллагаа гэж та ташаа ойлгосон юм биш биз? Энэ удаад, арга зүй түгээн дэлгэрүүлэх зөвлөх профессор Х.Такахата, М.Камата нарын ирүүлсэн тайлбарыг доор толилуулж байна.

Кёозай Кэнкюү буюу “Хичээлийн бэлтгэл судалгаа” гэдэг ухагдахууныг “Хичээлийн агуулгыг боловсролын байр сууринаас судлах судалгаа шинжилгээ” хэмээн тодорхойлж болно. Уг тодорхойлолт дахь “Боловсролын байр суурь” нь өргөн цар хүрээтэй ойлголт ба үүнд дараахи зүйлүүд хамаарна.

- Хичээлийн агуулгын тухай мэдлэг<sup>\*1</sup>: Ойлголт нь гүнзгий байх тусам илүү сонирхолтой хичээл явуулах боломжтой. (Кёозай Кэнкюү-гийн эрдмийн тал)
- Хичээлийн агуулгын түүх нийгэм, соёл боловсролын үнэ цэнийг харгалзан үзэх.
- Энэхүү хичээлийн агуулгаар дамжуулан хүүхдүүдэд эзэмшүүлэх чадварыг судлах.
- Хүүхдийн сэтгэхүйн хөгжлийн үе шатны (оюуны чадавхи, мэдрэмж) тухай ойлголт<sup>\*2</sup>: Хүүхдүүдийн хувьд сонирхолтой, ойлгомжтой байдлаар хичээлийн агуулгыг засан сайжруулахад ашигладаг.
- Тухайн насны хүүхдүүд ер нь хөгжлийн аль үе шатанд байна вэ? Түүнд нь тохирсон ямар арга зүй байж болох вэ?
- Тухайн ангийн хүүхдүүд хөгжлийн аль үе шатанд байна вэ? (хүүхэд бүр дээр өөр) Түүнд нь тохирсон ямар арга зүй байж болох вэ?
- Хүүхдүүдийн хувьд сонирхол татахуйц, ойлгомжтой хичээлийн агуулгын ямар дэс дараалал, зохион байгуулах ямар арга зам байж болох вэ?
- Хүүхдийн сэтгэн бодох үйл явцын судалгаа: Хүүхдүүд хичээлээ сонирхон идэвхитэй оролцож, ойлгоход дөхөм байдлаар хичээлийн агуулгыг засан сайжруулахад ашигладаг.
- Тухайн насны хүүхдүүд ямар түвшинд сэтгэн бодох вэ? Түүнд нь тохирсон ямар арга зүй байж болох вэ?
- Тухайн насны хүүхдүүд ямар түвшинд сэтгэн бодох вэ? (хүүхэд бүр дээр өөр) Түүнд нь тохирсон ямар арга зүй байж болох вэ?
- Хүүхдүүдийн хувьд сонирхол татахуйц, ойлгомжтой хичээлийн агуулгын ямар дэс дараалал, зохион байгуулах ямар арга зам байж болох вэ?

Багш нар “Кёозай кэнкюү”-г өдөр тутам байнга хийх шаардлагатай. Өнөөдөр, хөдөлмөр зүтгэлтэй Япон багш нарын ачаар янз бүрийн нэгж хичээлтэй холбоотой судалгааны арвин туршлага сургамж хуримтлагдсаар байна (Тодорхой нэг судлагдахуунтай холбоотой ном сэтгүүл, эрдмийн зөвлөлүүдээс гаргадаг эмхэтгэл г.м). Монголд ч багш нар өөрсдийн судалгаа, туршлага сургамжаа бусдад танилцуулах орчин нөхцөл, боломж бололцоотой эрдмийн зөвлөлийн уулзалт цуглаан, ном сэтгүүл байвал зүгээр.

Багш нар өөрсдийнхөө өдөр тутам хийдэг “Кёозай кэнкюү” болон урьд өмнөх бусад багш нарын хийсэн судалгааны үр дүнд тулгуурлан ээлжит хичээлийн төлөвлөлт, бэлтгэлийг хийдэг байна.

#### Анхаарах зүйл:

“Кёозай кэнкюү”-гийн тухай үндсэн ойлголт нь олонхи судлагдахуунд ижилхэн байх боловч, тодорхой нэг агуулгын хувьд судлагдахуун бүр дээр өөр байх тохиолдол ч байдаг. Жишээлбэл, дээр дурьдсан зүйл нь байгалийн ухааны хувьд дараахи онцлогтой.

\*1: Хичээлийн агуулгын тухай мэдлэг

Байгалийн ухааны хичээлүүдэд сорил туршилт, ажиглалт голлодог учир хичээлийн үед явуулах сорил туршилт болон ажиглалтын талаархи багшийн мэдлэг, ойлголт чухлаар тавигдана. Ялангуяа, аюулгүй сорил туршилт явуулахад юу хэрэгтэй болох, сурагчдын хувьд ойлгомжтой сорил туршилт, ажиглалт хийхийн тулд юунд анхаарвал зохих зэргийн талаар урьдчилан тооцох нь чухал. Тиймээс, эдгээр асуудлыг батлахын тулд туршилт (бэлтгэл туршилт) хийх нь ч нэг чухал Кёозай кэнкюү болдог.

\*2: Хүүхдийн сэтгэхүйн хөгжлийн үе шатны тухай ойлголт

Насанд хүрэгчдийн хувьд амар хялбар мэт санагдах сорил туршилт, ажиглалт нь хүүхдүүдэд зарчим, бүтэц зохион байгуулалт нь үл ойлгогдох юм уу, эсвэл гүйцэтгэх ажил нь нарийн төвөгтэйгээс хүүхдүүд чадахгүй байх явдал олонтаа тохиолддог. Ийм тохиолдолд, багш хүүхдийнхээ хөгжлийн үе шатыг бодолцон, үргэлж хүүхдийнхээ түвшинд тохирсон сорил туршилт, ажиглалтын аргачлагыг бэлтгэх шаардлагатай байдаг байна.

### Хүрээлэн буй орчны боловсрол гэж юу вэ?

Япон дахь сургалтад оролцогчид, Нагано мужийн Чино хотын хүүхдүүдийн хамт хүрээлэн буй орчны боловсролын хөтөлбөрт хамрагдсан. Энэхүү хүрээлэн буй орчны боловсрол гэж чухам юу вэ?

Хүрээлэн буй орчны боловсрол нь хүрээлэн буй орчин ба түүнтэй холбоотой асуудалд анхаарал хандуулахын зэрэгцээ тулгарч буй асуудлыг шийдвэрлэх, шинэ асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэхэд хувь хүн, эсвэл хамт олноороо шаардлагатай мэдлэг чадвар, үйл ажиллагаа, хүсэл сонирхол бүхий иргэн болгон хөгжүүлэх явдлыг гол зорилгоо болгодог.

Эрт цагаас хүмүүс бидний ахуй амьдралыг байгаль орчин тэтгэсээр ирсэн билээ. Харин, сүүлийн үед хүн төрөлхтний үйл ажиллагаа нь байгаль орчин нөхөн сэргэх хэмжээ хязгаараас давж, дэлхийн газар орон бүрт хүрээлэн буй орчны асуудлууд (дэлхийн дулаарал, ойн мөхөл, биологийн төрөл зүйлийн усталт, цөлжилт, усны нөөцийн хомсдол г.м) үүссээр байна.

Сургуулийн боловсрол нь хүүхдүүдэд байгаль экологийн арвин баялаг, түүнийг хэрхэн тогтвортой ашиглах тухай судлах таатай боломж олгодог гэж хэлж болно. Япон Улс 2006 оноос Боловсролын тухай хуулиндаа хүрээлэн буй орчны боловсролыг тусган оруулжээ.

Төсөлт ажил хичээлээр орон нутгийнхаа байгаль орчны тухай, Байгалийн ухааны хичээлээр амьтан ургамлын тухай, Нийгмийн хичээлээр эх орныхоо газар нутаг, ой модны тухай, Гэр ахуйн хичээлээр “Эд юмсыг хайр гамтай хэрэглэх” тухай сурч судлах нь хүрээлэн буй орчны боловсролтой шууд холбогдоно.



### Японд сургалт зохион байгуулав

Төслийн загвар аймаг, дүүргийн БСГ/БХ-ийн мэргэжилтэн, загвар сургуулиудын сургалтын менежер, багш нарын төлөөлөл (22 хүн) Япон Улсад 2 долоо хоногийн сургалтад (2011 оны 26/IX-08/X) хамрагдлаа. Уг сургалтын зорилго нь, 1) Японы багш нарын мэргэжил дээшлүүлэх тогтолцооны талаар судлах, 2) Суралцахуйд суурилсан багшлах арга зүйн талаархи ойлголтоо гүнзгийрүүлэх явдал байв.

Японы боловсролын тогтолцоо, нэгж болон ээлжит хичээлийн хөтөлбөр, самбар ашиглалт, Кёозай кэнкюү, суралцах чадварын үнэлгээ судалгааны тухай лекцүүд сонссоноос гадна Токио хот болон Нагано мужийн Боловсролын нэгдсэн төвөөр зочилсон. Түүнчлэн бага, дунд, ахлах сургуулиудаар зочлон, өнөөг хүртэл хөгжүүлсэн “Хичээл ажиглах нүд”-ээ ашиглан Байгалийн ухаан, бага дунд ангийн Математик, Мэдээлэл зүйн хичээлүүдэд ажиглалт хийсэн.

Оролцогчид Японы багш нарын арга зүйг гүнзгийрүүлэн судласан төдийгүй, янз бүрийн хэлбэрээр хэрэгждэг багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын бүтэц тогтолцооны талаар ч судалсан. Японы “Хот мужийн боловсролын зөвлөл” нь багш нарыг ажилласан жил (1,5,10 жил), албан тушаалаас (Ерөнхий эрхлэгч, хичээлийн эрхлэгч, сургуулийн захирал) хамааран янз бүрийн сургалтад хамруулдаг. Нөгөө талаар, бүх сургуулиуд дээр “Сургууль төвтэй судалгаа”, багш нарын санаачилсан сургалтууд зохион байгуулагддаг.

Сургууль төвтэй судалгаа нь сургуулиуд боловсролын зорилтоо биелүүлэхийн тулд сургууль нийтээрээ нэг сэдэв сонгон хэрэгжүүлдэг ажил юм. Юуны өмнө боловсролын зорилтдоо нийцүүлэн хүүхдүүдийнхээ төлөв байдлыг судалж үзнэ. Дараа нь “Хүүхдээ хэрхэн хөгжүүлэх вэ?” гэдгээ судлан, судалгааны сэдвээ (Жишээ: “Харилцааны чадвар эзэмшин, өөрийн санаа бодлоо илэрхийлж чаддаг хүүхэд болгон хүмүүжүүлэх”, “Бие даан суралцаж, идэвхитэй сэтгэн бодох чадвартай хүүхэд болгон хөгжүүлэх”) сонгодог. Ингээд явал судалгааны зорилго биелэгдэх вэ гэсэн таамаглалыг дэвшүүлэн, бүх судлагдахуунаар агуулга, үйл алхам, сургуулийн ажлаа төлөвлөдөг. Сургууль төвтэй судалгаанд хичээлийн судалгааг ашигладаг. Сургуулийн захирал, орлогч захирал, багш нар судалгаат хичээлд ажиглалт хийж, сургууль төвтэй судалгаа нь хүүхдээ хөгжүүлэхэд тус нэмэр болсон эсэхийг хэлэлцүүлнэ. Мөн, их дээд сургуулийн багш, мэргэжилтэн, сургуулийн захирлаар ажилласан туршлагатай багш нар зэрэг хөндлөнгийн сургагч багш нарын зөвлөгөөг сонсох, судалгааны үр дүнгийн уулзалтад эцэг эхчүүдийг урьж оролцуулах зэрэг ажлыг зохион байгуулж байна.

Япон багш нарын Монголд тохирохуйц туршлага, сургамжийг авч ажилдаа ашиглах нь зүйтэй мэт санагдана.



### Цаашдын төлөвлөгөө

- 2012 оны 1-3 сар: Төслийн загвар аймаг, дүүргийн сургалт болон хичээлийн судалгаанд мониторинг хийх
- 2012 оны 5-6 сар: Загвар аймаг, дүүргийн хичээлийн судалгааны хэрэгжилтийн тайлангийн хурлыг зохион байгуулах
- 2012 оны 9-10 сар: Төслийн загвар аймаг, дүүргийн сургалт болон хичээлийн судалгаанд мониторинг хийх
- 2012 оны 11 сар: Үндэсний хэмжээний бүсчилсэн сургалт зохион байгуулах

Түүнчлэн, багш бэлтгэдэг их дээд сургуульд зориулсан сургалт, төслийн загвар бус аймгуудын арга зүйн шинэчлэлд үзүүлэх дэмжлэг, Индонези Улстай туршлага солилцох зэрэг ажлуудыг төлөвлөж байна.

### Төслийн багийн холбоо барих хаяг:

Хаяг: Утас/Факс: 976-11-322552, 98900323  
Өрөө 119, Засгийн газрын 3-р байр, Е-мэйл хаяг: <jicacctm@gmail.com>  
БСШУЯ,  
Багатойруу-44, Улаанбаатар хот, Вебсайт: <http://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/004/index.html>  
Монгол Улс





## Төслийн мэдээлэл 2012 оны 6 дугаар сар №4

### Төслийн 2 дахь жилийн үйл ажиллагаа өндөрлөлөө

#### Төслийн 2 дахь жилийн үйл ажиллагаа өндөрлөлөө

Төслийн загвар аймаг, дүүрэгт зохион байгуулсан гол ажлууд 2010 оны 9 сараас (2010-2011 оны хичээлийн жилийн эхэн) эхэлсэн. Аймгийн түвшинд арга зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх түшиц сургуулиар сонгогдсон загвар сургуулиуд “Загвар сургуулийн баг” бүрдүүлэн ажиллаж, 2010 оны 11 сард төслийн нэгдсэн сургалтад хамрагдсан бөгөөд төслийн эхний жилээс загвар сургуулиуд дээр хичээлийн судалгаа хийж эхэлсэн. Хэдийгээр янз бүрийн хүндрэл бэрхшээл тулгарч байсан боловч, БСШУЯ-ны 2010-2011 оны хичээлийн жилийн зорилгод бүх сургуулиуд дээр хичээлийн судалгаа хийх тухай тусгагдсан нь хичээлийн судалгаагаар дамжуулан арга зүйгээ сайжруулахын ач холбогдлыг ойлгоход дөхөм болсон юм.

2011-2012 он та бүхний хувьд ямаршуухан жил болж өнгөрсөн бол оо? Энд, төслийн эхний жилийн үйл ажиллагааны талаар эргэн саная.

- Хичээлийн судалгааны аргачлалыг танилцуулах зорилго бүхий сургалтыг 2011 оны 8 сарын 29-30-нд, багш бэлтгэдэг улсын болон хувийн их дээд сургуулиудын төлөөллийг оролцуулан зохион байгуулсан.
- 9 сарын 4-22-нд, ЖАЙКА-ийн үнэлгээний баг ирж ажиллан, тус төслийн хэрэгжилтийн явцын тохиромжтой байдлыг судалсны зэрэгцээ, үр өгөөж, ач холбогдолын хувьд төсөл зорилтоо биелүүлэх боломжтой эсэхийг судлах зорилгоор “Явцын үнэлгээ” хийсэн.
- 9 сарын дундаас 10 сарын дунд хүртэлх хугацаанд, загвар сургуулиуд дээр 2 дахь удаагийн хичээлийн судалгааны мониторингийг зохион байгуулсан.
- 9 сарын 26-наас 10 сарын 8-нд, загвар аймаг, дүүргийн БСГ/БХ-ийн мэргэжилтэн, загвар сургуулиудын сургалтын менежер, багш нарын төлөөлөлд зориулсан сургалтыг Япон Улсад зохион байгуулсан.

- 11 сарын эхэнд “Багшлахуйн арга зүйн хөгжлийг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх бүсчилсэн сургалт”-ыг зохион байгуулсан.
- 2012 оны 1-3 сард, төслийн загвар аймаг, дүүргээс зохион байгуулсан сургалтад, мөн загвар сургуулиудад хичээлийн судалгааны мониторингийг 3 дахь удаа зохион байгууллаа.
- 2012 оны 3 сараас төслийн загвар бус аймагт чиглэсэн үйл ажиллагааг эхлүүлсэн.
- 5 сард, Индонези Улстай хичээлийн судалгааны туршлага солилцох хөтөлбөрийг хэрэгжүүллээ.
- 2012 оны 6 сарын 3-4-нд, бүх аймаг, дүүргийн хичээлийн судалгааны хэрэгжилтийг хянах, арга зүйн шинэчлэлийн бүсийн сүлжээ буй болгох зорилгоор нэгдсэн семинар зохион байгууллаа.

#### Төслийн сүүлийн жилийн (3 дахь жил) үйл ажиллагааны талаар

Эдүгээ төслийн сүүлийн жилийн үйл ажиллагааг эхлүүлээд байгаа бөгөөд цаашид дараахи хүснэгтэд дурьдсан төслийн хүрэх үр дүн болон зорилго ямар хэмжээнд биелж байгаад анхаарал тавьж ажиллах шаардлага тулгарч байна.

Хэтийн зорилго	Бага, дунд сургуулийн сурагчдын сурлагын амжилт дээшилсэн байна.
Эрхэм зорилго	Загвар болон бусад аймаг, дүүргийн багш нар суралцахуйд суурилсан багшлах арга зүйг туршин хэрэгжүүлнэ.
Төслийн зорилго	Суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлнэ.
Үр дүн 1	Бүх аймаг, дүүргийн суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх багийн үр чадвар дээшилнэ.
Үр дүн 2	Загвар аймаг, дүүрэгт хичээлийн судалгааны загвар бий болно.
Үр дүн 3	Загвар аймаг, дүүргийн багш нарын суралцахуйд суурилсан багшлах үр чадвар дээшилнэ.
Үр дүн 4	Суралцахуйд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх орчин боловсронгуй болно.

#### “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”

Монгол Улсын боловсролын салбарт 2005 оноос цогц чадамжид суурилсан бага, дунд боловсролын стандарт, 2008 оноос Сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн билээ. Эдгээр шинэ стандарт, хөтөлбөрт сурагчдын өөрсдөө мэдлэг бүтээх чадварыг хөгжүүлэх, улмаар багш бүр сургалтын шинэ арга зүйг эзэмших явдал зайлшгүй чухлаар тавигдаж байна.

Иймд БСШУЯ болон ЖАЙКА хамтран 2010 оны 4 сараас “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж эхэлсэн.

Төслийн зорилго нь “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил (2006-2009)” төслийн хүрээнд боловсруулсан багшид зориулсан зөвлөмж, эдүгээ боловсруулж буй сургалтын модулийг ашиглан сургалт зохион байгуулж, суралцахуйд суурилсан багшлах арга зүйг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх бүтэц, тогтолцоог бэхжүүлэх явдал юм.

Тус төслийг МУИС, МУБИС, Боловсролын хүрээлэн болон төслийн 1 дэх шатанд оролцсон хүмүүсээс бүрдсэн “Мэргэжлийн баг” загвар аймаг, дүүргээр сонгогдсон СХД болон Булган, Завхан аймгуудтай хамтран хэрэгжүүлж байна.

#### Гарчиг:

Төслийн 2 дахь жилийн үйл ажиллагаа	1
Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл	1
Загвар бус аймаг, дүүрэгт чиглэсэн үйл ажиллагааг эхлүүлээ	2-3
Загвар аймаг, дүүргийн загвар бус сургуулиудад зориулсан сургалт зохион байгууллаа.	3
Самбар төлөвлөлт гэж юу вэ?	3
Цаашдын төлөвлөгөө	4
Төслийн бодлогын зохицуулагчийн танилцуулга	4
ЖАЙКА-аас бусад улс орны багшлахуйн арга зүйн шинэчлэлд үзүүлж буй тусламж дэмжлэг	4



## Төслийн загвар бус аймагт чиглэсэн үйл ажиллагааг эхлүүлээ

2011 оны 9 сард зохион байгуулсан ЖАЙКА-ийн явцын үнэлгээгээр, төслийн зорилгыг биелүүлэхэд загвар бус аймаг, дүүргийн боловсон хүчнийг сургахад анхаарал хандуулах, төслийн загвар болон загвар бус аймгийн уялдаа холбоог сайжруулах явдал тулгамдсан асуудал болж байна нэг хэмээн тодорхойлсон. Үүнээс улбаалан, 2012 оны 3 сараас загвар бус аймагт чиглэсэн үйл ажиллагаагаа эхлүүлсэн юм.



Архангай аймгийн зориулсан сургалтын явц  
(Зураг 1: Бага ангийн математикийн баг  
Зураг 2: Физикийн баг  
Зураг 3: Хүн байгалийн судалгаат хичээл)

### Архангай аймагт зориулсан сургалт

2012 оны 3 сарын 15-17-нд Мэргэжлийн багийн зүгээс Архангай аймагт сургалт зохион байгууллаа. Архангай аймгийн баг зам тээврийн ослын улмаас өнгөрсөн жилийн 11 сард бүх аймагт зориулан явуулсан сургалтад ганцаар оролцож чадаагүй тул энэ удаагийн сургалтыг тус аймагт зориулан зохион байгуулсан юм.

Уг сургалтаар суралцахуйд суурилсан багшлах арга зүй буюу арга зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх арга болох хичээлийн судалгааны тухай лекц, дадлага ажлуудыг зохион байгуулсан. Оролцогчид сургагч багш нарын удирдлагаар хамтран хичээлд бэлтгэж, сургалтын 3 дахь өдөр судалгаат хичээл заасан.

Дунд ангийн математикийн багийнхан квадратыг 4 тэнцүү хуваан гурвалжин дүрс үүсгэх, түүний талбайг олох зэрэг дадлага ажил хийсэн. Оролцогчид үйл ажиллагаагаараа дамжуулан, хүүхдүүд өөрсдөө томъёог бодож олох нь чухлыг, мөн сонирхолтой болохыг сайтар ойлгож авч байлаа. Химийн багт Архангайн аймгийн БСГ-ын дарга болон сургалт явуулсан сургуулийн захирал, сургалтын менежерүүд оролцсон ба хичээл заах багшийг тусалж дэмжин, судалгаат хичээлийн бэлтгэлийг хангасан. “Хяналт тавьж, үнэлгээ өгөх байр сууринаас биш, арга зүйн шинэчлэлийг хийх нэгэн гишүүн болохын хувьд удирдлагууд ч хичээлийн судалгаанд идэвхитэй оролцох нь чухал юм гэдгийг анзаарлаа” хэмээн тэд хэлцгээж байв.

### Баян-Өлгий аймаг дахь хичээлийн судалгааны мониторинг

4-р сарын 23-27-нд, төслийн загвар аймаг болох Завхан аймгийн баг Баян-Өлгий аймаг дахь хичээлийн судалгаанд мониторинг хийлээ. Мониторингийн баг зорилгоо танилцуулахдаа “Бидний зорилго бол шалгалт хийх явдал биш юм. Хичээлийн судалгаа загвар бус аймагт хэрхэн хэрэгжиж байгаа, сайн тал болон сайжруулах зүйл нь юу болох, цаашид сургалтад юуг анхаарах вэ? гэдгийг олж илрүүлэх явдал юм” гэж байлаа.

Аймгийн БСГ-ын дарга Т.Тогторхан “Сүүлийн жилүүдэд улсын ерөнхий шалгалтын дундаж үзүүлэлтээр манай аймаг нийт 21 аймгийн дотроос 21-р байрт бичигдэж байсан явдал бидний санааг зовоож байсан хэдий ч, сурлагын чанарт анхаарч ажилласны үр дүнд 2010 онд 17-р байр, 2011 онд 15-р байрт орсон ахиц гарсан. Багшлахуйн арга зүйг шинэчлэх энэхүү төслийн үр дүнд манай аймгийн багш нарын арга зүй сайжирч, улмаар сурагчдын сурлагын чанарт ахиц гарч байна. Цаашид улсын хэмжээнд 10-р байрт ахих зорилт тавин ажиллаж байна” хэмээн өгүүлсэн юм.

Мониторингийн баг Өлгий сумын 2, 3-р сургууль болон Улаанхус, Ногооннуур сумын ахлах сургуулиуд дээр ажиллан, хичээлийн судалгааны зөвлөгөө өгөх зэргээр харилцан үр бүтээлтэй ажилласан.

### Дархан-Уул аймаг дахь хичээлийн судалгааны мониторинг

2012 оны 5 сарын 1-4-нд Дархан-Уул аймгийн хичээлийн судалгааны хэрэгжилт, арга зүйн шинэчлэлийн явцтай танилцах зорилгоор тус аймгийн 4 сургуульд төслийн Япон зөвлөх багш нараас гадна Сэлэнгэ аймгийн БСГ-ын 3 мэргэжилтнээс бүрдсэн баг очиж ажиллан, хичээлийн судалгааны мониторинг хийлээ.

Дархан-Уул аймаг нь МУИС, МУБИС зэрэг их сургуулиудтай хамтран ажиллаж, хичээлийн судалгааны тухай танилцуулах “Мянган багшийн сургалт”-ыг зохион байгуулж эхлээд байгаа юм. Дархан-Уул аймгийн БСГ нь аймгийнхаа багш нарын арга зүйг шинэчлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр урам зориг дүүрэн ажиллаж байна.



Загвар аймаг, дүүргийн загвар бус сургуулиудад зориулсан сургалтын явц

## Хэнтий аймаг дахь хичээлийн судалгааны мониторинг

2012 оны 5 сарын 6-12-нд, Дорнод аймгийн БСГ болон мэргэжлийн багийн хамтарсан 7 гишүүнтэй мониторингийн баг Хэнтий аймагт ажиллаж, тус аймгийн хичээлийн судалгааны хэрэгжилттэй танилцлаа. Аймгийн төвийн 4 сургууль, 2 сумын сургууль дээр зохион байгуулсан 20 судалгаат хичээлтэй танилцав. Багш нарын дийлэнх нь хичээлийн судалгааны талаар үндсэн ойлголттой болсон нь сайшаалтай боловч, зарим нэг ойлголт, тухайлбал хичээлийн бэлтгэл судалгааг хамтран хийх, хүүхдээ судлах, ажиглах ур чадвараа дээшлүүлэх, шүүмжлэгчийн бус байрнаас хандах, хичээлээ нарийн төлөвлөх, самбар төлөвлөх зэрэгт анхаарах шаардлагатай болох нь харагдаж байлаа.

Мониторингийн багийн гишүүд тус аймгийн багш нарт санал зөвлөгөө өгч, туршлагаасаа хуваалцсан төдийгүй, зүүн бүсийн багш нарын арга зүйг хөгжүүлэхэд Дорнод, Хэнтий аймгийн хамтын ажиллагаа, туршлага солилцооны “Түүр” тавигдсанаараа чухал ач холбогдолтой үйл ажиллагаа болсон юм. Та бүхний цаашдын ажил үйлсэд өндөр амжилт хүсье.

### **Загвар аймаг, дүүргийн загвар бус сургуулиудад зориулсан сургалт зохион байгууллаа**

2012 оны 1-4 сард, төслийн загвар сургуулиуд тойрог/бүсийнхээ бусад сургуулиудад зориулан хичээлийн судалгааны мэдлэгээ хуваалцах, түгээн дэлгэрүүлэх сургалтыг зохион байгууллаа.

Загвар сургуулиудын сургагч багш нар өөрсдийн мэдлэг туршлагадаа тулгуурлан сургалтад бэлтгэж, үр дүнтэй сургалт зохион байгуулахаар хичээж ажилласан юм.

Сургалтанд оролцогчид хичээлийн судалгаа нь багшлахуйн арга зүйгээ сайжруулах, боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлэх нэг чухал арга хэрэгсэл болохын ач холбогдлыг ойлгон, суралцах эрмэлзэл дүүрэн сургалтын үйл ажиллагаанд оролцсон. Багш нар хичээлээ хамтран бэлтгэх нь сайн хичээл заах, хамтдаа арга зүйгээ сайжруулахад чухал нөлөөтэй гэдгийг сайтар ойлгож авсан. Нэг оролцогч “Би боловсролын салбарт 30 гаруй жил багшилж байна. Энэ хугацаанд багшийн арга зүйг сайжруулахад чиглэсэн, өөрөөр хэлбэл өдөр тутамд хичээлээ заах арга зүйг сайжруулахад чиглэсэн үр дүнтэй ийм сургалт цөөн байлаа” хэмээн сэтгэгдлээ хуваалцсан юм.

### **Самбар төлөвлөлт гэж юу?**

Самбар төлөвлөлтийн тухай олонтаа яригддаг. Судалгаат хичээлийн хэлэлцүүлэг дээр бүгд “Сайн хичээл хийхэд самбар төлөвлөлт чухал” гэгцгээдэг. Харин бодит байдал дээр хэрхэн төлөвлөвөл зохих вэ? Юун дээр анхаарах ёстой юм бол ? 2012 оны 5 сард Урава Их Сургуулийн Ватари Фүмико багш Монголд ирж ажилласан бөгөөд самбар төлөвлөлтийн тухай уншсан түүний лекцийг та бүхэнд толилуулж байна.

Самбар төлөвлөлт гэдэг нь хичээлийн явцад багш, хүүхдүүд самбарт бичиглэл хийн, тэр нь тодорхой хугацаанд самбарт хадгалагдан үлдэхийг хэлнэ. Дэлгэцэнд харуулж буй зүйл болон үзүүлэн зэргийг ч үүнд багтааж болно.

Ингэхэд яагаад заавал самбарыг төлөвлөх ёстой вэ?

Самбар төлөвлөлтийг өдөр тутам хичээлээр зорьсон зүйлээ биелүүлэх зорилгоор хийдэг. Самбар төлөвлөлтийг сайн хичээл (Хүүхдүүдэд мэдлэг чадварыг тулган ойлгуулах бус, мэдлэг чадвар эзэмшүүлэхийн зэрэгцээ сэтгэн бодох чадварт сургадаг хичээл) зохион байгуулах нэг арга гэж хэлж болно.

#### Самбар төлөвлөлтийн үүрэг

1. Хүүхдүүд санаа бодлоо бусад хүүхдүүдтэй хуваалцаж, асуудлыг анги хамт олноороо шийдвэрлэхэд нь чиглүүлэхэд тус дөхөм болдог.

2. Хичээлийн үйл явцыг илэрхийлж өгдөг.

3. Мэдээллийг тэмдэглэн хадгалдаг.

Самбарт хүүхдүүдийн сэтгэн бодох, тунгаах үйл явцыг тэмдэглэх нь тэдний сэтгэн бодох чадварыг хөгжүүлж өгдөг байна. Ингээд Японд самбарыг хэрхэн төлөвлөдөг тухай жишээг доор танилцуулъя. Үүнд,

• Самбарын зүүн дээд талаас баруун доод тал гэсэн дэс дарааллаар бичиглэлийг хийдэг.


• Тухайн хичээлээр дэвшүүлж буй асуудлыг самбарын зүүн дээд талд дөрвөлжин нүдэн дотор гаргацтай, ойлгомжтой бичдэг.

• Дэвшүүлсэн асуудлын тухай хүүхдүүдээр бодуулах зорилгоор асуултууд бичдэг. (Асуулт их чухал. Яагаад энэ аргыг сонгов, өөр арга байж болох уу гэх мэт хүүхдээр бодуулахаар асуулт байх)

• Хүүхдийн хариултын хажууд хариулсан хүүхдийн нэрийг бичих, эсвэл хэн аль хариултыг зөвшөөрч буй нь харагдах байдлаар нэр бичсэн цаас наадаг.

• Самбарыг харахад тухайн хичээлийн сэдэлжүүлэлт, үйл явц, дүгнэлт зэрэг нь ойлгогдохуйц байх ёстой.

• Сайн самбар төлөвлөлт нь хүүхдийн дэвтэр хөтлөлтөд ч дөхөм үзүүлнэ.



Японы залуу сайн дурын гишүүн Сано багшийн (Багануур дүүргийн “Боловсрол” ЦС) самбар төлөвлөлт ба хүүхдийн дэвтэр хөтлөлт

### ЖАЙКА-гаас бусад улс орны багшлахуйн арга зүйн шинэчлэлд үзүүлж буй тусламж дэмжлэг

ЖАЙКА байгууллагын суурь боловсролд үзүүлж буй тусламж дэмжлэг нь 1.Боловсрол сургалтын боломжийг өргөжүүлэх (Сургуулийн барилга барих), 2.Боловсролын чанарыг дээшлүүлэх (Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт), 3.Боловсролын менежментийг сайжруулах (Сургуулийн удирдлага менежмент, боловсролын удирдлагын албан хаагчдын чадварыг бэхжүүлэх) гэсэн 3 чиглэлээр хэрэгжиж байна.

Монгол Улсад хэрэгжүүлж буй төсөл нь Боловсролын чанарыг дээшлүүлэх (Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт) чиглэлээр ажиллаж байна. Багш нар бол боловсролын чанарыг тодорхойлох нэг чухал хүчин зүйл юм. Өндөр ур чадвартай багш нарыг бэлтгэхэд багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт зайлшгүй шаардлагатай хэмээн Японд үздэг бөгөөд тасралтгүй, үе шаттайгаар багшийн хөгжлийг дэмжих тогтолцоог буй болгоход дэмжлэг үзүүлж байна.

Монголоос гадна Индонези, Пакистан, Бангладеш, Камбоджи улсуудад ч хичээлийн судалгаагаар дамжуулан багшийн багшлах ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн дэмжлэгийг үзүүлж байгаа юм. Ази төдийгүй төв Америк, Африкт бага ангийн математик, байгалийн ухааны хичээлийн багш нарын ур чадварыг дээшлүүлэх тогтолцоог буй болгоход ч хамтран ажиллаж байна.

Багшийг хөгжүүлэх, боловсон хүчнээ хуваарилах тухай ярих байтугай, багш бэлтгэх явдал нь өөрөө асуудалтай байгаа улс орнууд ч цөөнгүй байдаг байна. Багш тасралтгүй хөгжихийн чухлыг Японы туршлагад тулгуурлан бусад улс орнуудад ч сурталчлан таниулж ажиллах болно.



### Цаашдын төлөвлөгөө

Дараахи байдлаар төслийн цаашдын үйл ажиллагааг төлөвлөж байна.

- 2012 оны 6 сар: Япон Улсад сургалт зохион байгуулах
- 2012 оны 9-10 сар: Төслийн загвар аймаг, дүүргийн хичээлийн судалгаанд мониторинг хийх
- 2012 оны 10 сар: ЖАЙКА-аас тус төслийн эцсийн шатны үнэлгээ хийх
- 2012 оны 11 сар: Үндэсний хэмжээний бүсчилсэн сургалт зохион байгуулах
- 2013 оны 1-2 сар: Төслийн загвар аймаг, дүүргийн сургалт болон хичээлийн судалгаанд мониторинг хийх
- 2013 оны 2 сар: Төсөл эцэслэхтэй холбогдуулан семинар зохион байгуулах

Түүнчлэн сургалтын модулиудыг эцэслэн боловсруулах, багш бэлтгэдэг их дээд сургуульд зориулсан сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг төлөвлөсөн. Төслийн загвар бус аймаг, дүүрэгт зориулсан үйл ажиллагаагаа ч үргэлжлүүлэн хэрэгжүүлэх болно.

### Төслийн бодлогын зохицуулагчийн мэндчилгээ

Миний бие энэ оны 4 сараас эхлэн төслийн бодлогын зохицуулагчаар томилогдон ажиллаж байна.

БСШУЯ болон ЖАЙКА байгууллагын хамтран хэрэгжүүлж буй тус төслийн хүрээнд бага дунд сургуулийн багш нарын суралцахуйд суурилсан багшлах арга зүйг сайжруулах зорилгоор хичээлийн судалгаа хийхэд үзүүлж буй дэмжлэг нь боловсролын чанарыг сайжруулах, ялангуяа сурагчдын сурлагын амжилтыг сайжруулахад ихээхэн нөлөө үзүүлэх нь дамжиггүй юм.

Тиймээс хичээлийн судалгаа хийх аргачлал, түүнийг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх тогтолцоог буй болгох үйлсэд миний зүгээс санаачлагатай, үр дүнтэй ажиллах болно.

Ж.Энхтүвшин

### Төслийн багийн холбоо барих хаяг:



Хаяг: Өрөө 119, Засгийн газрын 3-р байр,  
БСШУЯ, Багагойруу-44, Улаанбаатар  
хот, Монгол Улс

Утас/Факс: 976-11-322552, 98900323  
E-мэйл хаяг: <jicacctm@gmail.com>

Вебсайт (JICA-ийн вебсайт дотор):  
<http://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/004/index.html>

**Төсөл вебсайттай боллоо!**  
<http://hicheeliin-sudalгаа.mn/>  
Хичээлийн судалгааны арга  
зүйд суралцах, багш нар  
болон сургуулиуд хоорондоо  
туршлага солилцох,  
хамтран ажиллах том  
боломж нээгдлээ.



## Төслийн мэдээлэл 2012 оны 10 дугаар сар №5

### “Хичээлийн судалгааны хэрэгжилтийн нэгдсэн зөвлөгөөн” (2012.6.3-4)

Улаанбаатар хотод төслийн загвар аймаг, дүүрэг болон бусад аймаг, дүүргийн БСГ-ын мэргэжилтэн, загвар сургуулиудын багш удирдлагаас бүрдсэн 100 гаруй хүн оролцсон “Хичээлийн судалгааны хэрэгжилтийн нэгдсэн зөвлөгөөн” зохион байгуулагдлаа.

*Зөвлөгөөний зорилго:*

- 2011-2012 оны хичээлийн жилд төслийн загвар аймаг, дүүргийн загвар сургуулиудад зохион байгуулсан “Хичээлийн судалгаа”-ны хэрэгжилтийн үр дүн, сургамж, саналаа солилцох.

- Төслийн загвар аймаг, дүүрэг, загвар сургуулийн багийн гишүүд 2012 оны 11 сард зохион байгуулах “Үндэсний хэмжээний сургалт”-ад сургагч багш болох чадвартай болох.

- Багшлахуйн арга зүйг сайжруулах зорилготой бүсийн хамтын ажиллагааны сүлжээ буй болгох.

Оролцогчид эхний өдрийн үдээс өмнө тус тусын бүс дэх хичээлийн судалгааны хэрэгжилтийн тухай тайлагнан, “Сайн хичээл”-ийн бодит жишээнд тулгуурлан илтгэл тавьж, мэдээлэл солилцов.

Үдээс хойш судлагдахуунаар хуваагдан ажиллаж, дор нэр дурьдах 2 сургуулийн судалгаат хичээлд ажиглалт хийв. Судалгаат хичээлүүдийг хичээл заасан багшаас гадна мэргэжлийн баг болон ЖАЙКА-гийн залуу сайн дурын гишүүд хамтран бэлтгэсэн нь онцлог байлаа. Судалгаат хичээлийн дараа, бүх судлагдахууны онцлогт тохирсон хичээлийн бэлтгэл судалгааны талаар харилцан ярилцсан.

Хоёр дахь өдрийн үдээс өмнө, Индонези Улсад зохион байгуулсан хичээлийн судалгааны туршлага солилцох хөтөлбөрийн тухай тайлан, 2012 оны 3 сарын Архангай аймаг дахь сургалтын тайлан, загвар бус Баян-Өлгий, Хэнтий, Дархан-Уул аймагт хийсэн хичээлийн

судалгааны мониторингийн тайлан, НБГ-ын тайланг танилцуулсан. Дараа нь оролцогчид 6 багт хуваагдан, мэргэжлийн багийн сургагч багшийн удирдлагаар 2011 оны 11 сарын сургалтаас хойш бүх аймаг, дүүрэгт зохион байгуулсан хичээлийн судалгааны хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэсэн арга зам, төслийн загвар аймаг, дүүргийн баг болон мэргэжлийн багаас ямар дэмжлэг хүсч буй тухай санал бодлоо солилцсон юм.

Төслийн загвар аймгийн оролцогчид энэ удаагийн зөвлөгөөнд оролцоноор үндэсний түвшинд сургалт зохион байгуулах итгэл дүүрэн болж чадсан болов уу. Загвар бус аймгийн оролцогчид энэ удаагийн зөвлөгөөнөөр ямар сэтгэгдэлтэй буцсан бол? Энэ тухай зөвлөгөөний төгсгөлд оролцогчдоос авсан асуулга судалгааны дүнг эдүгээ нэгтгэж байна.

Зөвлөгөөний сүүлийн өдөр оролцогчдоос асуулга судалгаа авч үзэхэд, бүх тайлан илтгэлийн сэтгэл ханамж 5 үзүүлэлт бүхий үнэлгээгээр 4-өөс дээш гэсэн үнэлгээ авчээ. Судалгаат хичээлийн тухайд, ялангуяа хэлэлцүүлэг зохион байгуулсан нь хичээлийн судалгааны талаархи ойлголтоо дээшлүүлэхэд хэрэг болсон гэсэн байв. Цаашид, орон нутгийн түвшинд багшлахуйн арга зүйн шинэчлэлийг зохион байгуулахад Боловсролын газрын идэвхитэй оролцоо, бүс нутаг болон сургуулиуд хооронд туршлага солилцох явдал чухал гэсэн санал олноор гарсан юм.



Физикийн судалгаат хичээл  
(Гэрлийн хугарлын туршилт)

### Төслийн тухай

Монгол Улсын боловсролын салбарт 2005 оноос цогц чадамжид суурилсан бага, дунд боловсролын стандарт, 2008 оноос Сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн билээ. Эдгээр шинэ стандарт, хөтөлбөрт сурагчдын өөрсдөө мэдлэг бүтээх чадварыг хөгжүүлэх, улмаар багш бүр сургалтын шинэ арга зүйг эзэмших явдал зайлшгүй чухлаар тавигдаж байна.

Иймд БСШУЯ болон ЖАЙКА хамтран 2010 оны 4 сараас “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж эхэлсэн.

Төслийн зорилго нь “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил (2006-2009)” төслийн хүрээнд боловсруулсан багшид зориулсан зөвлөмж, эдүгээ боловсруулж буй сургалтын модулийг ашиглан сургалт зохион байгуулж, суралцахуйд суурилсан багшлах арга зүйг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх бүтэц, тогтолцоог бэхжүүлэх явдал юм.

Тус төслийг МУИС, МУБИС, Боловсролын хүрээлэн болон төслийн 1 дэх шатанд оролцсон хүмүүсээс бүрдсэн “Мэргэжлийн баг” загвар аймаг, дүүргээр сонгогдсон СХД болон Булган, Завхан аймгуудтай хамтран хэрэгжүүлж байна.

### Гарчиг:

Хичээлийн судалгааны хэрэгжилтийн нэгдсэн зөвлөгөөн	1
Төслийн тухай	1
Индонезитэй туршлага солилцох хөтөлбөр	2
Япон дахь сургалтын тайлан	2
Багш бэлтгэдэг их дээд сургуульд зориулсан тайлан	2
Загвар аймаг, дүүрэг, загвар сургуулиудын мониторингийн тайлан	3
Загвар бус аймаг дахь сургалт болон мониторинг	3
Хичээлийн судалгааны видео хичээл	3
Цаашдын төлөвлөгөө	4
Төслийн хаалтад бэлтгэх тухай	4
Төслийн эцсийн шатны үнэлгээний үр дүн	4

Сүмэдэн аймгийн Жатинангүр  
дунд сургуульдИндонезийн УБЯ-ны ЕБГ-ын  
дарга ноён М.Хатгатай хийсэн  
уулзалт

### Индонезитэй туршлага солилцох хөтөлбөр (2012.5.19-30)

ЖАЙКА нь 1998 оноос Индонезийн Боловсролын чанарыг дээшлүүлэх, ялангуяа Байгалийн ухааны боловсролыг шинэчлэхийн тулд хичээлийн судалгаа зохион байгуулах, түгээн тэлгэрүүлэх зорилгоор төсөл хэрэгжүүлж ирсэн. 2009 оноос “Анхан шатны дунд боловсролын чанарыг дээшлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж байна. Хичээлийн судалгааны туршлага арвин Индонезийн боловсролын өнөөгийн байдал, хичээлийн судалгааны онцлог, туршлага сургамжаас суралцан, цаашид Монгол Улсын хичээлийн судалгааны менежментийг сайжруулах, Монгол дахь хичээлийн судалгааны талаар танилцуулах замаар Мэргэжлийн багийн хүсэл эрмэлзлэлийг дээшлүүлэн чадавхийг нь бэхжүүлэхэд дөхөм үзүүлэх зорилгоор Индонезитэй хичээлийн судалгааны туршлага солилцох хөтөлбөрийг зохион байгууллаа. Хөтөлбөрт БСШУЯ, Боловсролын Хүрээлэн, НБГ, Булган, Завхан, Дорнод, Сэлэнгэ аймгуудын БСГ болон МУИС, МУБИС-ийн төлөөлөл оролцлоо.

Индонезийн УБЯ-нд боловсролыг чанаржуулах, багш нарыг чадваржуулах чиглэлээр хийгдэж буй үйл ажиллагаа, хичээлийн судалгааны менежмент, хэрэгжилттэй танилцаж, Индонезийн БИС-ийн МБУФ-ийн хичээлийн судалгааны мэргэжлийн багийн гишүүдтэй уулзаж санал солилцсон. Түүнчлэн, Баруун Ява мужийн Боловсролын Газар, Индонезийн Боловсролын Чанарыг Батламжлах Байгууллага, Сүмэдэн аймгийн Боловсролын Хэлтэс, Жатинангүр дунд сургуулиар зочлон, хичээлийн судалгааны хэрэгжилтийн бодит байдалтай танилцахын сацуу хичээлийн судалгааг Монголд хэрхэн хэрэгжүүлж буй тухайгаа ч танилцуулж байлаа. Жатинангүр дунд сургууль дээр 8-р ангийн Нийгмийн ухааны хичээлд ажиглагчаар оролцон, хэлэлцүүлгийн явцтай танилцаж, туршлага судлах бололцоо олдсон юм.

### Япон дахь сургалт (2012.6.16-30)

Төслийн I, II шатны загвар аймгийн БСГ-ын мэргэжилтэн, загвар сургуулиудийн удирдлагуудад зориулсан сургалтыг Токио хот болон Канагава, Нагано мужид амжилттай зохион байгууллаа. Энэ удаагийн сургалтын зорилго нь 1) Япон багш нарын арга зүйгээс суралцах 2) Японы сургуулиуд багш нарынхаа ур чадвар, арга зүйг хэрхэн сайжруулж байгаа болон сургуульд суурилсан хичээлийн судалгааны хэрэгжилттэй танилцах, тэднээс суралцах явдал байв.

Сургалтын үеэр улсын бага, дунд, ахлах сургууль, Токио Гакугэй Их сургуулийн харьяа бага, дунд сургууль зэрэг 9 сургуулиар зочлон, сургуульд суурилсан хичээлийн судалгаа зохион байгуулах менежменттэй танилцаж, хичээлд ажиглалт хийх нээлттэй судалгааны өдөрлөгт оролцсон. Түүнчлэн самбар төлөвлөлт, математик болон байгалийн ухааны хичээлийн бэлтгэл судалгаа, ЖАЙКА-гийн бусад улс орны боловсролын салбарт хэрэгжүүлж буй төслийн тухай танилцуулга сонслоо. Нагано мужид бага, дунд сургуулиар зочилсны зэрэгцээ “Нагано мужийн багшийн нэгдсэн төв”-д багш нарын мэргэжил дээшлүүлэх тогтолцоотой танилцсан. Японы хамгийн эртний сургууль болох Мацүмото хотын “Кюү-Кайчи сургууль” музейд “Хүүхэд асрагч хүүхдийн бичсэн зохион бичлэг”-ийг үзээд зарим багшийн нүдэнд нулимс цийлэгнэж байлаа.

Сургалтын төгсгөлд оролцогчид сурч мэдсэн зүйлээ тус бүрийн аймаг, сургуульдаа хэрхэн хэрэгжүүлэх тухай төлөвлөгөө боловсруулсан. Уг төлөвлөгөөнд самбар төлөвлөлтийг сайжруулах, сургуулийнхаа зорилго, зорилтыг оновчтой тодорхойлох, бага сургуулиудад ном уншлагын цагтай болох зэрэг зүйлүүдийг тодорхой тусгасан байлаа. 8 сарын сүүлд зохион байгуулагдсан “Багш нарын бага хурал”-ын үеэр ч Япон дахь сургалтын үр дүнг танилцуулсан. Энэ маягаар оролцогчид Японд үзэж сонссоноо зөвхөн өөрсдөө бус, сургууль болон аймагтаа танилцуулахыг хүсч байна.

Минэмачи бага сургуулийн  
захирал, хичээлийн эрхлэгчийн  
хамт (Токио хот, Оота дүүрэг)

### Багш бэлтгэдэг их дээд сургуульд зориулсан сургалт (2012.9.13-14)

Багш бэлтгэдэг их, дээд сургуулийн багш нар, сургалтын албаны дарга нарт зориулсан сургалтыг Улаанбаатар хотод зохион байгууллаа. Уг сургалтад МУИС, МУБИС, Ховд их сургууль, Архангай аймгийн Багшийн сургууль, Баян-Өлгий аймгийн Багшийн сургууль, Дорнод дээд сургууль, Гурван-Эрдэнэ дээд сургуулийн төлөөлөл оролцон, багш бэлтгэдэг их, дээд сургуулийн бакалаврын сургалтад зориулсан “Хичээлийн судалгаа” хичээлийн хөтөлбөрийн агуулга, арга зүйтэй танилцав.

Оролцогчдод хичээлийн судалгааны бодит жишээг үзүүлэх зорилгоор төслийн I шатны загвар 45-р сургууль дээр Хүн байгаль, Хими, Математикийн хичээлүүдээр судалгаат хичээл зохион байгуулсан. Хичээлийн бэлтгэл судалгаатай урьдчилан танилцсаны үндсэн дээр судалгаат хичээлд ажиглалт хийн, хичээлийн хэлэлцүүлэгт оролцох байдлаар дадлага ажлыг зохион байгуулсан нь оролцогчдод хичээлийн судалгааны алхам, үйл явцыг ойлгоход дөхөм болсон болов уу.

Сургалтын төгсгөлд дээрхи сургуулиуд тус бүр сургалтын төлөвлөгөө, хөтөлбөртөө “Хичээлийн судалгаа” хичээлийг тусган оруулах боломжийн талаар хэлэлцэж, давуу болон сул талаа тодорхойлон ярилцсан юм.

Дунд ангийн Математикийн  
хичээлийн дадлага ажил

## Загвар сургуулиудын үйл ажиллагаа

Хуудас 3

Мэргэжлийн баг 2012.16/IX-21/IX-нд, Завхан аймгийн Чандмань-Эрдэнэ, Шилүүстэй, Завханмандал, Тосонцэнгэл, Сонгино, Баянтэс сумын сургуулиудад зочлон, хичээлийн судалгааны мониторинг хийв. Энэ удаагийн мониторингийн үеэр, бүсийн сургууль төдийгүй Ховд аймгийн багш нарын төлөөлөл ч зорин ирснээс үзэхэд, бүх сургуулиуд хичээлийн судалгаанд идэвхитэй оролцож байгаа нь харагдсан. Ажиглагчид хүүхдүүдийг сайтар ажиглаж, хэлэлцүүлгийн үед хичээл заасан багшийг шүүмжлэх бус сайжруулах арга замын талаар ярилцаж чадаж байв. Мөн, хүүхдүүд хичээл дээр биеэ барилгүй идэвхитэй оролцож байгаагаас үзэхэд, хичээлийн судалгаа өдөр тутмын үйл ажиллагааных нь нэг хэсэг болсон сургууль ч байлаа.



Бага ангийн Математикийн судалгаат хичээл /Тосонцэнгэл/

24/IX-29/IX-нд, Булган аймгийн загвар сургуулиудад хичээлийн судалгааны мониторинг хийсэн. Төсөлт ажил хичээл дээр хүүхдүүд ааруул хийх, өөрсдийн амьдардаг сумын тухай судалснаа бусдадаа тайлбарлах зэргээр янз бүрийн үйл ажиллагаа зохион байгуулж байлаа. Хэлэлцүүлэгт мэргэжлийн багийн гишүүд зөвлөгөө өгч байсан нь багш нарт, шинэ залуу багш нарт их хэрэг болсон болов уу. Мөн, зарим сургууль долоо хоног бүр хичээлийн судалгаанд цаг гарган ажилладаг, багш нар нь хичээлийн судалгаа хийх өндөр эрмэлзлэлтэй байдгийг олж мэдсэн. Мониторингт Такахата багш оролцон, бүх сургуулиудад хичээлийн судалгаа болон хичээлийн бэлтгэл судалгааны талаархи суурь мэдлэг, хүүхдүүдэд ойлгомжтой самбар төлөвлөлтийг хэрхэн хийх тухай зөвлөгөөг өгч байлаа.



Физик 12-р сургууль

УБ хотод Мэргэжлийн баг болон НБГ-ын мэргэжилтнүүд хамтран хичээлийн судалгааны мониторинг хийв. 67-р сургуулийн Химийн хичээлээр урвалж ашиглан, угаалгын нунтаг зэрэг өдөр тутмын амьдралд хэрэглэгддэг бодисын шинж чанарыг судлах туршилт явуулсан. Ирээдүй ЦС дээр, аяганд ус хийхэд, түүн доторхи зоос тодорч харагдана гэдэг туршилтаар сэдэлжүүлэн, гэрлийн хугарал сэдэвт хичээл зохион байгуулагдсан. 12-р сургууль дээр тоглоомон машин ашиглан, хөдөлгөөний энергийг тооцож үзэх хичээл зохион байгуулагдсан. Эдгээр хичээлүүд нь агуулга тохиромжтой, оновчтой туршилт, үйл ажиллагаа хийгдсэн нь сэтгэгдэл төрүүлсэн.



4-р ангийн Төсөлт ажил судалгаат хичээл /Булган/

Гэхдээ, дээрхи загвар аймаг, дүүргийн сургуулиудад хэт их өнгийн цаас, өнгийн пламастер, проектор зэргийг ашигласан “Харагдах байдалдаа анхаарсан” хичээл, багш нь хүүхдээ сайн ойлгохгүй байгаа хичээлүүд ч харагдаж байсан. Цаашид ч, хүүхдүүдийн хичээлээ ойлгож буй эсэхийг тандах аргыг бодож олох нь чухал. Хүүхдүүдийн дэвтрийг шалгаж үзэх ч бас л нэг арга юм.

## Хичээлийн судалгааны видео хичээл



Төслийн хүрээнд, дунд ангийн Математикийн баг Нийслэлийн 67-р сургуулийн бага ангийн багш нартай хамтран "Биет ашиглан ус хэмжицгээ" сэдвээр хичээлийн судалгааны видео хичээл хийлээ.

Уг хичээл нь, хүүхдүүд бага ангийн Математикийн мэдлэг, чадвараа хэрхэн ашиглаж буй байдал, Математик сэтгэлгээний хөгжлийг үзэгчдэд ойлгомжтой байдлаар төлөвлөгдсөн бөгөөд сурагчдаар мэдлэг бүтээлгэх арга зүй, хичээлийн бэлтгэл судалгаа хийх аргыг багш нарт таниулан ойлгуулах зорилгоор Монголын нийт багш нарт зориулан бүтээсэн юм. Энэхүү видео киног "Sky forever" студид бүтээсэн бөгөөд цаашид Монгол Улсын бүх ЕБС-иудад олшруулан тараахаар төлөвлөж байна.

## Загвар бус аймаг дахь сургалт

Төслийн загвар бус аймагт зориулсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх 3 хоногийн сургалтыг загвар аймгийн баг болон мэргэжлийн баг хариуцан дараахи байдлаар амжилттай зохион байгууллаа.

1. Архангай аймгийн сургалт: 15/III-17/III (Мэргэжлийн баг)
2. Өвөрхангай аймгийн сургалт: 24/IX-26/IX (Булган аймгийн баг)
3. Сүхбаатар аймгийн сургалт: 27/IX-29/IX (Дорнод аймгийн баг)
4. Өмнөговь аймгийн сургалт: 1/X-3/X (Мэргэжлийн баг)

Дээрхи сургалтуудаар дамжуулан хичээлийн бэлтгэлээ багаараа хамтран хийж, судалгаат хичээл, ажиглалт хэлэлцүүлэг зохион байгуулан, хичээлийн хөтөлбөрөө сайжруулсан. Загвар бус аймгийн багш нар хичээлийн судалгаа хийх арга замын талаархи ойлголтоо гүнзгийрүүлсний зэрэгцээ, загвар болон загвар бус аймгууд туршлага солилцох бололцоог олгосон юм.

Эдгээр сургалт нь загвар бус аймгийн суралцахууд суурилсан багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэхэд ихээхэн дөхөм үзүүлсэн гэдэгт итгэж байна.



Өвөрхангай аймгийн сургалт: Судалгаат хичээлийн дараахи хэлэлцүүлэг

**Төслийн эцсийн шатны  
үнэлгээний үр дүн**

ЖАЙКА байгууллагын зүгээс төслийн хэрэгжилт дуусахаас өмнө төслийн зорилго биелсэн эсэхийг хэрэгцээ, нийцтэй байдал, үр дүнтэй байдал, үр өгөөжтэй байдал, үр нөлөө, тогтвортой байдал гэсэн үзүүлэлтээр үнэлгээ хийлээ.

Тус төслийн эцсийн шатны үнэлгээ судалгааг 10 сарын 1-нээс 18-нд зохион байгуулсан бөгөөд төслийн эцсийн шатны үнэлгээний баг Улаанбаатар хот төдийгүй Булган, Завхан аймгуудад ажиллаж, эдгээр аймгуудын БГ, загвар болон загвар бус сургуулиудад зочлон ярилцлага авсан юм.

Үнэлгээний эцэст, Монгол Улсын БШУЯ болон мэргэжлийн багийн төлөөлөл оролцсон “Хамтарсан зөвлөлийн хурал” дээр үнэлгээний үр дүнг танилцуулсан. Хэрэгцээ, нийцтэй байдал, үр дүнтэй байдал, үр өгөөжтэй байдал зэрэг нь өндөр үзүүлэлттэй гарсан боловч, төсөл дууссаны дараа багшлахуйн арга зүйг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө тодорхой бус байсан хэмээгээд, тогтвортой байдал дунд зэрэг гэсэн үнэлгээ өгсөн.

Үнэлгээний багийн зүгээс БШУЯ-нд хандан, цаашид мэргэжлийн багийн гишүүдийг идэвхитэй ашиглах, БГ-ын мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, багшлахуйн арга зүйн шинэчлэлд оролцож буй багш нарыг үнэлэх зэрэг үйл ажиллагааг төсөл дууссаны дараа хэрэгжүүлэхийг хүссэн зөвлөмж гаргасан билээ.

**Төслийн багийн хаяг****доорхи байдлаар****оорчлогдлоо!**

Хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот, Энхтайваны  
Өргөн Чөлөө 10, Багш Хөгжлийн Ордон, 4  
давхар, 405 тоот  
Утас/Факс: 976-7012-0503, 9890-0323

**Загвар бус аймаг, дүүрэгт чиглэсэн мониторинг**

2011 оны 9 сард ЖАЙКА-гийн явцын үнэлгээний багаас, өгсөн тус төслийн зорилгыг хэрэгжүүлэхэд загвар бус аймаг, дүүргийн чадавхийг дээшлүүлэхэд анхаарах, загвар болон загвар бус аймгийн уялдааг сайжруулах шаардлагатай гэсэн зөвлөмж гаргасан.

Төслийн хүрээнд, өмнөх хуудсанд танилцуулсан сургалтаас гадна загвар бус аймгуудын хичээлийн судалгааны мониторинг зохион байгуулж байна. Өнөөг хүртэл загвар аймгийн багтай хамтран дараахи мониторингийг зохион байгуулсан.

1. Баян-Өлгий аймаг: 22/IV-28/IV (Завхан аймгийн баг)
2. Дархан-Уул аймаг: 30/IV-5/IV (Сэлэнгэ аймгийн баг)
3. Хэнтий аймаг: 6/V-12/V (Дорнод аймгийн баг)
4. Чингэлтэй дүүрэг: 24/XI-28/XI (НБГ)
5. Дундговь аймаг: 8/X-12/X (Мэргэжлийн баг)
6. Хөвсгөл аймаг: 24/X-30/X (Булган аймгийн баг)



**Өмнөговь аймгийн сургалт:**  
Судалгаат хичээлийн явц



**Хэнтий аймгийн мониторинг:**  
Физикийн хичээл дээр хүүхдүүд туршилт хийж байгаа нь

**Цаашдын төлөвлөгөө**

2012.11: “Багшлахуйн арга зүйн хөгжлийг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх бүсчилсэн сургалт”:

1. УБ (1): 11/3-11/6
2. УБ (2): 11/10-11/13
3. Завхан: 11/11-11/14
4. Булган: 11/14-11/17
5. Дорнод: 11/14-11/17
6. Сэлэнгэ: 11/14-11/17

2012.12: Сургалтын модулийг бэлэн болгох

2012.12-2013.01: Загвар аймаг, дүүргийн загвар бус сургуулиудад зориулсан сургалт болон сургалтын мониторинг

2013.02: Загвар сургуулиуд дахь хичээлийн судалгаа болон хичээлийн судалгааны мониторинг

**Төсөл дуусах дөхсөнтэй холбогдуулан**

Тус төслийн үйл ажиллагаа нь хүүхдийн суралцахуйд гол анхаарлаа хандуулж ирсэн. Сайн сурлагатай хүүхдийг илүү сайн сургана гэхээс илүү, сурлагын хоцрогдолтой хүүхэд гаргалгүй, бүх хүүхдийн суралцахуйн чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж ирлээ.

Хичээлийн судалгаагаар дамжуулан бага, дунд ангийн багш нарын арга зүйг сайжруулахад чиглэгдсэн тус төсөл хэрэгжсэнээр олонхи сургуулийн багш нарын заах арга зүй өөрчлөгдөж байгаа тухай сонслоо. Сургуулийн удирдлага, багш нар та бүхэн, тус төсөл дууссан ч гэсэн хүүхдэд анхаарлаа хандуулсан үйл ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэхийг хүсье. Сурлагаар хоцорсон хүүхдийн (Хичээл хоцорсон хүүхэд) тоо цөөрч байна уу? Бүх хүүхдүүд хичээлд оролцон, хичээлээ ойлгож чадаж байна уу?

**Төслийн багийн холбоо барих хаяг:**

Төслийн багийн Е-мэйл хаяг: &lt;jicactm@gmail.com&gt;

**Төслийн вебсайт:** <http://hicheeliin-sudalgaa.mn/>Вебсайт: <http://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/004/index.html>



**Монгол Улсын Боловсрол, Шинжлэх Ухааны Яам**  
**Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (JICA)**



“Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”

**Төслийн мэдээлэл**  
**2013 оны 2 дугаар сар №6**

**“БАГШЛАХУЙН АРГА ЗҮЙН ХӨГЖЛИЙГ ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ БҮСЧИЛСЭН СУРГАЛТ”**

